



Геополитик, үндэсний ашиг сонирхол ба шашны үнэт зүйлс: Монголын нийгэм-улс төрийн харилцааг рационал эгоизмын үүднээс шинжлэх нь

Ойдовын Хатанболд

Ph.D

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
khatanboldo@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь рационал эгоизмын онолын хүрээнд Монголын нийгэм-улс төрийн харилцаанд үндэсний үзэл, шашны үнэт зүйлс, геополитикийн тооцоолол хэрхэн огтлолцож байгааг шинжилнэ. Судалгааны зорилго нь нэг талаас рационал эгоизм Монголын кейсийг тайлбарлах чадавхтай эсэхийг шалгах, нөгөө талаас иргэдийн улс төрийн сонголт, хошуучлалын шалгуур, шашин-үндэсний ижилслийн уялдааг эмпирик баримтад тулгуурлан тайлбарлахад оршино. Судалгаа нь дискурсив шинжилгээ, онолын харьцуулсан задлал, хоёрдогч өгөгдөлд тулгуурласан тайлбарлах статистикийг хослуулсан холимог арга зүй ашиглав. 2017-2019, 2022-2024, 2024-2026 оны суурь судалгаануудын санал асуулга, фокус бүлгийн ярилцлага, шинжээчийн ярилцлагын үр дүнд дахин боловсруулж ашигласан бөгөөд хэмжилтийн түвшинд үндэсний үзэл, шашны хамаарал, улс төрийн хошуучлалын шалгуур, институцийн итгэл, оролцооны хэв маягийг индикатор болгон авч үзэв. Үр дүнгээс харахад үндэсний ижилсэл нь улс төрийн сонголтын хүчтэй шалгуур бөгөөд “өргөтгөсөн би” гэсэн ойлголтоор тайлбарлагдах хамтын рационал эгоизмын илрэл болж байна. Шашин, ялангуяа буддын шашин нь төр-шашны институцийн нэгдлийг бус, харин ёс суртахууны хяналт, нийгмийн итгэлцэл, хамтын амьдралын өртгийг бууруулах “ёс суртахууны соёлын капитал”-ын үүрэг гүйцэтгэж байна. Геополитикийн түвшинд гуравдагч хөршийн бодлого, тусгаар тогтнолын асуудал, баялгийн менежмент нь жижиг улсын рационал эгоизмын стратегийн хэлбэр болж байна. Корреляцийн тайлбарын түвшинд улс төр-шашин болон геополитикийн эрсдэлт нөхцөл байдлын хооронд дунд түвшний уялдаа ажиглагдах ба энэ нь иргэд ёс суртахууны найдвартай байдал, үндэсний аюулгүй байдлыг хамтад нь үнэлж байгааг харуулна. Иймээс Монголын улс төрийн төлөвшил нь примитив эгоизмаас урт хугацааны хариуцлагатай рационал эгоизм руу шилжих завсрын үе шатандаа байна гэсэн дүгнэлтийг дэвшүүлэв.

Түлхүүр үгс: рационал эгоизм, Монголын нийгэм, үндэсний үзэл, шашны үзэжт зүйлс, нийгэм-улс төрийн харилцаа, улс төрийн нам, цахим ардчилал, шийдвэр гаргалт

1. Оршил

Орчин үеийн нийгмийн онолд хувь хүний ашиг сонирхол, хамтын сайн сайхан, институцийн тогтвортой байдал гуравын уялдаа хамгийн төв асуудлын нэг хэвээр байна. Эгоизм хэмээх ойлголт уламжлалт ёс суртахууны сэтгэлгээнд голдуу сөрөг утга агуулдаг боловч орчин үеийн улс төрийн философи, эдийн засаг, тоглоомын онолд урт хугацааны үр дагаврыг тооцдог рационал эгоизм нь хамтын ажиллагааг

тайлбарлах чухал хүрээ болсон. Энэ нь хүн төрөлхтний түүх, нийгмийн харилцааны хөгжил нь хувь хүний ашиг сонирхол ба хамтын сайн сайхны хоорондын тэнцвэрийг эрэлхийлсэн тасралтгүй үйл явц юм. Сонгодог утгаараа “эгоизм” буюу хувийн ашгийг урьтал болгох үзэл нь нийгмийн эв нэгдэлд саад учруулах хүчин зүйл мэт харагддаг ч, орчин үеийн философи болон улс төрийн шинжлэх ухаанд



“рационал эгоизм” хэмээх ойлголт нь нийгмийн тогтвортой байдлын нэгэн тулгуур багана болж ирлээ. Рационал эгоизм нь хувь хүн өөрийн ашиг тусыг зөвхөн өнөөдрийн сиймхийгээр бус, харин алсын хараатай, ухаалгаар тооцоолж, бусадтай хамтран ажиллах нь эцсийн дүндээ өөрт нь хамгийн их ашигтай гэдгийг хүлээн зөвшөөрөх үзэл юм. Гэвч энэхүү “ухаалаг тооцоолол” нь вакуум орчинд бус, харин тухайн нийгмийн соёл, сэтгэлгээний томоохон баганууд болох үндэсний үзэл болон шашны хүчин зүйлсээр дамжин хэрэгжиж байдаг.

Өнөөгийн даяаршсан нийгэмд улс орнууд болон хувь хүмүүс өөрсдийн “би” төвт ашиг сонирхлоо хамгаалахдаа үндэсний ижилсэл болон шашны үнэт зүйлсийг хэрхэн хэрэгсэл болгож буйг судлах нь нэн чухал юм. Үндэсний үзэл нь хувь хүнийг илүү том “хамтын би”-д нэгтгэх замаар түүний аюулгүй байдлыг хангах рационал сонголт болдог бол, шашин нь нийгмийн харилцааны ёс зүйн хэм хэмжээг тогтоож, үл итгэлцлээс үүдэх зардлыг бууруулах механизмаар хангадаг.

Монгол Улсын нөхцөлд энэ асуудал онцгой ач холбогдолтой. Ардчилсан шилжилт, зах зээл, даяаршил, дижитал технологи, шашны дахин сэргэлт, геополитикийн эмзэг байршил, үндэсний ижилслийн шинэ эрэл зэрэг олон хүчин зүйл иргэдийн улс төрийн үнэлгээ, оролцоо, итгэлцлийн хэв маягийг зэрэг өөрчилж байна. Ийм нөхцөлд иргэд яагаад үндэсний эрх ашиг, ёс суртахууны шалгуур, шашны үнэт зүйл, эсвэл секуляр шалгуурыг улс төрийн сонголтын үндэс болгож байгааг рационал сонголтын хэлээр тайлбарлах боломж нэмэгдэж байна.

Энэхүү өгүүлэл нь Монголын нийгэм-улс төрийн харилцаанд үндэсний үзэл, шашны үнэт зүйл, геополитикийн эрсдэлийн төсөөлөл гурав ямар нөхцөлд хамтын рационал эгоизмын хэлбэрт шилжиж, ямар нөхцөлд примитив аминч байдлыг өдөөж болохыг шинжилнэ. Судалгааны үндсэн асуулт нь: иргэдийн үндэсний болон шашны үнэт зүйл улс төрийн сонголт,

хошуучлалын шалгуур, институцийн итгэлцэлд ямар замаар нөлөөлж байна вэ; мөн энэ нөлөөллийг геополитикийн эмзэг орчин хэрхэн дахин утгажуулж байна вэ гэдгийг рационал эгоизмын үзэл санааг Монголын нийгэм, улс төрийн харилцааны түвшинд авч үзэж, түүнд үндэсний үзэл ба шашны хүчин зүйлс хэрхэн нөлөөлж, хувийн ашгийг нийтийн сайн сайхантай уялдуулж буйг шинжлэх зорилготой.

Монгол Улс 1990 оноос хойш зах зээлийн эдийн засаг, ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр нийгмийн бүх хүрээнд гүнзгий өөрчлөлтүүд өрнөсөн. Энэхүү шилжилтийн үйл явц нь хувь хүмүүс, нийгмийн бүлгүүдийн үнэт зүйлс, хандлага, зан төлөвд ихээхэн нөлөөлснөөр рационал эгоист хандлага илүү тод илэрч эхэлсэн (Баасансүрэн Д, Хишигдаваа А, ба бусад, 2020, хуудсд. 13-16). Энэ нь өнөөгийн дэлхий ертөнцөд мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийг даган нийгмийн болоод улс төрийн амьдралын бүхий л салбарт гүнзгий өөрчлөлтийг авчирснаараа онцлог юм. Үүний нэг нь “цахим ардчилал”-ын талаарх ойлголт юм. Цахим ардчилал хэмээх эл ойлголт нь иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, Засгийн газар болон улс төрийн институтүүдийг иргэдэд ойртуулах чухал хэрэгсэл болон хувирсан. Үүний нэг чухал хэсэг нь улс төрийн намуудын бүтэц, үйл ажиллагаа, ялангуяа гишүүнчлэлийн бодлогод гарч буй шинэчлэл юм (УТЭЗС, Философийн хүрээлэн, 2024, хуудсд. 374, 376). Чухам эл үндэслэлийн хүрээнд монголын нийгмийн харилцаа, үндэсний үзэл, гэр бүлийн харилцаа, хамтын ажиллагааны хандлага, улс төрийн намуудын үйл ажиллагаа, иргэдийн оролцоо зэрэг асуудлыг рационал эгоизм хэмээх онолын хүрээнд шинжлэхийг зорив. Эдгээр харилцаанд шашны хүчин зүйл хэрхэн нөлөөлж улмаар иргэдийн улс төрийн хошуучлалын сонголтод ямар байдлаар илэрч буйг энэхүү өгүүллээрээ тодруулан гаргахыг оролдсон болно.

2. Онол, арга зүйн хүрээ

Рационал эгоизмыг *«Бусдад хор хүргэлгүйгээр, өөртөө хамгийн ашигтай бөгөөд зөв амьдрах урлаг»* гэсэн утгатай философийн үзэл

баримтлал хэмээн энгийнээр тайлбарлаж болох юм. Энгийн эгоист хүн зөвхөн өөртөө ашигтай бүхнийг бусдыг үл хайхран авдаг бол, рационал

эгоист хүн өөрийнх нь сайн сайхан байдал эргэн тойрны хүмүүсийн харилцаа болон нийгмийн тогтвортой байдлаас шууд хамааралтай гэдгийг маш сайн ойлгодог. Чингэхээр рационал эгоизмын үндсэн санаа нь өөрийн ашиг сонирхлыг нэгдүгээрт тавих нь зөв гэж үздэг ч, үүнийг “ухаалгаар” буюу дараах зарчмаар хэрэгжүүлэхийг хэлнэ. Үүнд:

- *Алсын хараатай ашиг тус* буюу одоохондоо олдох жижиг ашгаас илүү ирээдүйд гарах үр дагаврыг чухалчилна. Жишээ нь, хэн нэгнийг хуурч мөнгө олох нь түр зуурын ашиг боловч, нэр хүндээ алдах нь ирээдүйд илүү их хохирол авчирна гэж үзнэ.
- *Тусламж бол хөрөнгө оруулалт бөгөөд* бусдад туслах нь өөрийгөө золиослох хэрэг биш, харин ирээдүйдээ хийж буй хөрөнгө оруулалт юм. Бусдад тусалснаар эргэн тойрондоо таатай орчин бүрдүүлж, хэрэгтэй үедээ хариу тусламж авах боломжоо нэмэгдүүлнэ.
- *Хувийн хил хязгаар буюу* бусдын төлөө өөрийгөө золиослох албагүй ч, бусад хүмүүс ч мөн адил өөрийн гэсэн ашиг сонирхолтой эгоист байх эрхийг нь хүлээн зөвшөөрөх явдал мөн.
- *Үр дагаврыг тооцоолох буюу* шийдвэр гаргах бүрдээ «Энэ алхам миний амьдралд жилийн дараа ямар нөлөө үзүүлэх вэ?» гэж асуудаг. Үүнийг маш энгийнээр тайлбарлавал, оффисын гал тогоонд ганцхан зүсэм бялуу үлдсэн гэж төсөөлье: Чингэхэд *энгийн эгоист* бол хэнд ч мэдэгдэхгүйгээр шууд идчихнэ, харин *альтруист* (бусдын төлөө үзэлтэн) бол өөрөө маш их өлсөж байсан ч хамтран ажиллагсаддаа найр тавьж өгнө. Тэгвэл, рационал эгоист нь бялууг хувааж идэхийг санал болгоно эсвэл харилцаагаа сайжруулахыг хүсэж буй хүндээ өгнө. Учир нь тэр ганц зүсэм бялуунаас авах таашаалаас илүүтэйгээр хамт олонтойгоо тогтоосон сайхан харилцаа нь түүнд ирээдүйд илүү их ашиг тус авчирна гэдгийг тооцоолсон байдаг.

Үүнээс үзвэл, нийгэм, улс төрийн түвшинд рационал эгоизм нь зөвхөн хувь хүний сонголт биш, харин үндэстэн эсвэл бүлэг хүмүүс

өөрсдийн оршин тогтнол, хөгжил цэцэглэлтийг хэрхэн “ухаалгаар” тооцоолж байгаа тухай асуудал юм.

Чингэхээр рационал эгоизмын үзэл санаа нь “*Хувийн ашиг сонирхол хэрхэн нийтийн сайн сайханд хөтөлдөг вэ?*” гэсэн асуултад хариулт эрэлхийлсээр ирсний нэгэн тод жишээ. Үүнийг дараах үндсэн үе шатуудад буюу сонгодог үе, XIX зууны ёс суртахууны рационал эгоизм, XX зууны объективизм ба тоглоомын онол хэмээн хуваан үзэж гол төлөөлөгчдийн дэвшүүлсэн санаа, онолын үзэл баримтлалыг танилцуулж байна.

Рационал эгоизмын сонгодог үеийн онолын уламжлал нь Томас Гоббсын аюулгүй байдлын логикоос эхлэлтэй бөгөөд түүнийхээр бол хүнийг төрөлхийн эгоист амьтан хэмээн үзэж хүмүүс “*бүгд бүгдийнхээ эсрэг*” дайтаж байх нь хэн хэндээ ашиггүй, аюултай гэдгийг “рационал”-иар тооцоолсны үндсэн дээр өөрсдийн аюулгүй байдлын төлөө зарим эрхээ төрд шилжүүлж, “Нийгмийн гэрээ” байгуулдаг гэж үзсэн. Энэ нь рационал эгоизм улс төрийн тогтолцооны үндэс болох анхны санаа юм. Нэг ёсондоо “Хүний амьдралын хамгийн анхны бөгөөд үндсэн эрмэлзэл бол өөрийгөө хамгаалах явдал бөгөөд хүмүүс өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд л бусадтай хамтарч, энх тайвныг эрэлхийлдэг” (Thomas Hobbes, 1651). Харин Алексис де Токвиллийн “ухаалгаар ойлгосон хувийн ашиг сонирхол” (*self-interest rightly understood*) хэмээх ойлголт нь хүний хувийн ашиг ба нийтийн сайн сайхан заавал зөрчилдөнө гэж үздэггүй, харин урт хугацаандаа өөрийн эрх ашиг нь бусдын эрх ашиг, хамтын дэг журам, иргэний оролцоотой салшгүй холбоотойг ухааран үйлдэхийг хэлдэг: өөрөөр хэлбэл хүн зөвхөн шууд ашиг хонжооны араас бус, нийгмийн тогтвортой байдал, хууль ёс, харилцан итгэлцэл, сайн дурын нэгдэл зэрэг нийтийн нөхцөлийг хамгаалснаар эцэст нь өөрийн сайн сайхныг ч баталгаажуулна гэсэн санаа юм. А.Токвиль энэ зарчмыг ардчилсан нийгэм дэх хэт хувьч, тусгаарлагдах хандлагыг сааруулж, иргэдийг нийтийн хэрэгт оролцох ёс суртахууны-практик сэдэлтэй болгодог “*дундаж боловч түгээмэл*” иргэний ариун журам гэж тайлбарласан; өөрөөр хэлбэл

баатарлагаар өөрийгөө золиослох ёс суртахуунаас илүү даруухан ч ардчилалд илүү тогтвортой суурь болдог зан суртал гэж үзсэн (Tocqueville, 1840) нь дурдсан үеийн онолын гол тайлбар гэж үзэж болно. Хожим нь үүнийг Адам Смит хувийн ашиг ба нийтийн үр өгөөжийн уялдаа хэмээн чухалчилж, өөрийн “Үл үзэгдэгч гар”-ын онолоор рационал эгоизмын эдийн засгийн хамгийн том тайлбар юм. Түүнийхээр бол, хүн бүр өөрийн ашгийн төлөө хөдөлмөрлөх нь эргээд нийгэмд хэрэгцээт бараа, үйлчилгээ бий болгож, улс орны баялгийг бүтээдэг (Adam Smith, *The Invisible Hand*, (1 edition) 1759; (paperback) 2009;). Цаашлаад “...бид махны худалдагч, шар айраг исгэгч эсвэл талх баригчийн өгөөмөр сэтгэлийн ачаар оройн хоолоо иддэг юм биш. Харин тэд өөрсдийнхөө ашиг сонирхлыг (эгоизм) л хичээж буйн үр дүн” юм. Адам Смит, “*Үндэстнүүдийн баялаг*” (энд “*хувийн эгоизм = нийтийн баялаг*” гэсэн томъёо гарч ирнэ) бүтээлдээ энэ нь хувь хүний “би” төвтэй үйлдлүүд нийгэмд баялаг бүтээх хөдөлгүүр болдог гэдгийг батлахад ашиглагдана хэмээн дүгнэсэн (Adam Smith, *The Wealth of Nations*, November 19, 2015).

Харин Н.Г.Чернышевскийн ёс суртахууны рационализм нь рационал эгоизмыг нийгмийн дэвшилтэт үзэлтэй холбосон нь XIX зууны рационал эгоизмын суруь үндэс гэж болно. Түүнийхээр “ухаалаг хүн” бусдад хор хүргэх нь эцсийн дүндээ өөрт нь хортой гэдгийг ойлгодог. Тиймээс бусдад туслах, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэх нь тэр хүний хувьд хамгийн “ашигтай” бөгөөд “таашаалтай” сонголт болж хувирдаг. Энэ нь хувь хүний ашиг сонирхлыг нийгмийн үүрэг хариуцлагатай нэгтгэх оролдлого байв. Тэрээр рациональ эгоизмын ёс зүйн талаас авч үзэхдээ: “Хүн өөрийнхөө төлөө ажиллах нь ухаалаг эгоизм юм. Харин тэрхүү ‘*өөрийнхөө төлөө*’ гэсэн үйлдэл нь бусдад хор хүргэхгүй, харин ч тус болж байвал энэ нь дээд зэргийн ухаалаг хэрэг” мөн гэжээ (N.G.Chernyshevsky, 1863, (2nd edited translation 1989)). XX зууны объективизм ба тоглоомын онолын хувьд А.Рэндийн субъектийн автономит эгоизм нь рационал эгоизмыг улс төрийн либертари үзлийн тулгуур болгосон. Тэрээр хүний өөрийнхөө төлөө амьдрах эрхийг хамгийн

дээд ёс суртахуун гэж тунхаглаад, чөлөөт зах зээл болон хувийн өмч нь хувь хүмүүс бие биенийхээ эрхийг хүндэтгэн, харилцан ашигтай ажиллах (рациональ солилцоо) цорын ганц шударга тогтолцоо гэж үзсэн (Rand A, 1964). Харин Р.Акселродын давтагдмал хамтын ажиллагааны тоглоомын онол гэсэн шугамаар орчин үеийн нийгэм, улс төрийн шинжлэх ухаанд рационал эгоизмыг математик аргаар судалдаг болсон. Тухайлбал, түүний “Хоригдлын гацаа” (Prisoner's Dilemma) загвар нь хүмүүс яагаад хувиа хичээхээс илүү хамтран ажиллах нь урт хугацаандаа илүү ашигтай (рационал) болохыг нотолсон явдал байв. Энэ нь олон улсын харилцаа, дипломат ажиллагааны үндэс болдог (Axelrod R, 1984). Эдгээрийн нийтлэг цэг нь хүн өөрийн ашиг сонирхлыг бусдын хариу үйлдэл, институцийн нөхцөл, урт хугацааны эрсдэлтэй хамтад нь тооцдог гэх таамаглал юм. Гэвч дурдсан онолчдын байр суурь ижил биш, тодруулбал, Т.Гоббс аюулгүй байдлыг, А.Смит ашигт ажиллагааг, А.Д.Токвиль иргэний хамтын ажиллагааг, И.Г.Чернышевский ёс суртахууны тооцооллыг, А.Рэнд хувь хүний эрхийн дээдлэлийг түлхүү анхаарсан. Тиймээс рационал эгоизм нь нэг чиглэлийн онол бус, харин ашиг сонирхол ба нийтийн сайн сайхны холбоог өөр өөрөөр төсөөлдөг тайлбарын цөм хэмээн ойлгогдохыг илэрхийлж байна.

Хожмын үеийн судлаачдын хувьд, үндэсний үзлийг рационал эгоизмтай холбосон судалгаанд Р.Белкийн “*өргөтгөсөн би*” (Belk Russell W., 1988), Пьер ван де Бергийн “*өргөтгөсөн төрөл садан*” (Berghe, 2001), Яизель Тамирын либерал национализм (Yael Tamir, 1993) чухал байр суурийг эзэлдэг. Тухайлбал, Р.Белк үндэстэн, өмчлөл, харьяаллыг өөрийн хүрээний өргөтгөл гэж үзсэн (Belk Russell W., 1988) бол, Пьер Берге ижил гарал, хамтын хамгаалалтыг (van den Berghe, 1987), харин Яизель Тамир үндэстнийг хувь хүний эрх чөлөөг хэрэгжүүлэх соёлын хүрээгээр тодруулсан нь онцлог. Эдгээр гурван тайлбарын огтлолцол нь үндэсний үзлийг сохор сэтгэл хөдлөл бус, өөрийн урт хугацааны аюулгүй байдал, боломжийн бүтцийг хамгаалах прагматик хүрээ гэж унших боломж олгодог чухал юм. Харин шашны нийгэм-

улс төрийн үүргийг Д.Нортын институцийн онол (North, 1990), Ф.Фукуямагийн итгэлцлийн тайлбар (Fukuyama F, Trust: The Social Virtues and the Creation of Prosperity, 1995) онцгой ач холбогдолтой. Албан ёсны институци сул, хууль хэрэгжих өртөг өндөр нөхцөлд шашин, зан үйл, ёс суртахууны хэллэг нь албан бус дүрмийн тогтолцоо болж ажиллаж болно. Гэвч шашин үргэлж интеграцийн эх сурвалж болдоггүй бөгөөд зарим нөхцөлд гаднын нөлөө, ялгарал, улс төрийн мобилизацийн хэрэгсэл болж болох тул шүүмжлэлтэй авч үзэх шаардлагатай.

Энэхүү өгүүллийн *онолын шинэлэг тал нь* рационал эгоизмыг зөвхөн хувь хүний ашиг сонирхлын асуудал талаас нь бус, үндэсний ижилсэл, шашны ёс суртахуун, геополитикийн эрсдэлийг зангидсан олон түвшний тайлбарын хүрээ болгон ашиглаж буйд оршино. Чингэснээр монголын нийгэм-улс төрийн харилцаанд нийтлэг ажиглагддаг “*үндэсний үзэл ба шашны нөлөө*” гэсэн тайлбарыг илүү нарийвчилж, аль нь сэтгэл хөдлөл, аль нь тооцоолол, аль нь институцийн сул орон зайг нөхөж байгааг ялган харах боломжийг бүрдүүлж буйгаараа онцлог.

Арга зүйн хүрээ. Энэ судалгаанд рационал эгоизмыг “*хувь хүн, бүлэг, эсвэл улс өөрийн ашиг сонирхлыг урт хугацааны үр дагавар, хамтын орчны тогтвортой байдал, нэр хүнд, итгэлцэл, аюулгүй байдлын нөхцөлтэй уялдуулан тооцож шийдвэр гаргах хандлага*” гэж тодорхойлов. Энэ нь шууд ашиг, богино настай хожоог эрэмбэлдэг бүдүүлэг аминч байдлаас ялгаатай.

Өгүүллийн аналитик загвар дөрвөн түвшинтэй. *Нэгдүгээрт*, хувь хүний түвшинд рационал эгоизм нь улс төрийн сонголт, оролцоо, хошуучлагчид тавих шалгуурт илэрнэ. *Хоёрдугаарт*, хамтын түвшинд үндэсний үзэл нь “*өргөтгөсөн би*”-гийн логикоор хувь хүний аюулгүй байдал, нэр хүнд, боломжийн бүтцийг хамгаалах хүрээ болно. *Гуравдугаарт*, соёлын түвшинд шашин болон уламжлалт ёс суртахуун нь итгэлцэл, дотоод хяналт, хамтын амьдралын өртгийн бууралтыг дэмждэг “*ёс суртахууны соёлын капитал*” болж ажиллана. *Дөрөвдүгээрт*, манай улсын түвшинд геополитикийн эмзэг байршил нь үндэсний эрх ашгийг рационал тооцооллын хэлээр дахин тодорхойлох нөхцөл үүсгэнэ. Өөрөөр хэлбэл,

“*ёс суртахууны соёлын капитал*” гэдэг нь шашны институцийг улс төрийн ноёрхолд шууд шилжүүлэхийг бус, харин итгэл даах байдал, өөрийгөө хязгаарлах ёс суртахуун, нийтийн өмчид хандах хариуцлага, нийгмийн хамтын ажиллагааны бэлэн байдлыг өсгөж буй хэмжээг заана. Энэ ойлголт нь Ф.Фукуямагийн итгэлцлийн (Fukuyama F, Trust: The Social Virtues and the Creation of Prosperity, 1995) онолтой нийцэхийн зэрэгцээ шашныг улс төрийн хэт нөлөөний хэрэгсэл болгох эрсдэлийг шүүмжлэлтэйгээр зай барин тайлбарлах боломжийг олгоно гэсэн үг.

Ер нь рационал эгоизм нь хувь хүмүүс болон байгууллагууд үр ашгийг нэмэгдүүлэх эсвэл зардлыг багасгахын тулд мэдээлэлд үндэслэн логик, зорилготой шийдвэр гаргадаг гэсэн таамаглал дээр тулгуурладаг (Jorgensen M.B., Phillips L.J, 2002, p. 56). Энэ нь эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг дискурсын онол арга зүй, тухайлбал, Н.Ферклогийн гурван хэмжигдэхүүнт загварын үзэл баримтлалын хүрээгээр хуваан үзэх (Marianne Jorgensen, Louise Philips, 2002) замаар бодит амьдралд «*мөн чанарын хүчин төгөлдөр бүхий бүрдэл*» хэмээн үзэх цаг үеийн шаардлагыг бий болгодог. Рационализм нь хувь хүн эсвэл байгууллага тодорхой зорилгод хүрэхийн тулд логик, бодит мэдээлэлд тулгуурлан, үр өгөөжийг дээдлэх үйлдэл юм. Чингэхээр эгоизм нь бүх үйлдлийг хувийн ашиг сонирхол хөтөлдөг хэмээх үндсэн санааг агуулдаг. Энэ нь бүдүүлэг, энгийн, ёс зүйн, сэтгэл зүйн, рационал эгоизм гэх мэт хэд хэдэн хэлбэртэй байж болох бөгөөд сүүлийнх нь нийгмийн контекстэд хувь хүмүүс өөрсдийн сайн сайхан байдлыг дээдлэн шийдвэр гаргадаг болохыг илэрхийлдэг (Johnson, David W. Johnson, Roger T, 2000). Үндэсний үзэл хийгээд шашны итгэл үнэмшил нь тухайн хувь хүн эсвэл бүлгийн хувьд үнэт зүйлсийн тогтолцоог бүрдүүлж, улмаар тэдний рационал эгоист шийдвэр гаргалтад нөлөөлөх магадлалтай тул эдгээрийг судалгааны судлах үндэслэлээр сонгон авсан болно.

Судалгааны арга зүй, өгөгдөл ба хэмжилтийн логикийн хувьд, тус судалгаа нь холимог арга зүйн дизайнтай. *Нэгдүгээрт*,

онолын түвшинд дискурсив шинжилгээг ашиглан рационал эгоизм, үндэсний үзэл, шашин, геополитик, итгэлцэл гэсэн ойлголтуудын хоорондын утгын холбоог задлахыг зорьсон. *Хоёрдугаарт*, эмпирик түвшинд өмнө хэрэгжсэн суурь судалгаануудын хоёрдогч өгөгдөлд тайлбарлах статистикийн дахин боловсруулалт хийсэн бол, *гуравдугаарт*, фокус бүлгийн болон шинжээчийн ярилцлагын илэрхийлэмжийг сэдэвчилсэн кодчиллоор боловсруулж тоон үр дүнг тайлбарлах чанарын суурь болгон ашиглав.

Өгөгдлийн үндсэн эх сурвалж нь 2017-2019 оны улс төрийн соёлын судалгаа, 2022-2024 оны улс төрийн хошуучлалын судалгаа, 2024-2026 оны уламжлалт буддизм ба орчин үеийн нийгэм-улс төрийн үйл явцын талаар суурь судалгааны үр дүн болно. Эхний судалгаа нь Улаанбаатар хотын 6 дүүрэг болон хэд хэдэн аймгийн ойролцоогоор 1000 оролцогчийг хамарсан бол, дараагийн судалгаанууд нь шашин, хошуучлал, улс төрийн оролцооны хэв маягийг илүү нарийвчлан авч үзсэн. Анхдагч микро-өгөгдөлд үндэслэн энэхүү өгүүллийн тоон

боловсруулалтыг хийхдээ тайлан, хүснэгт, графикт буй хувь хэмжээ, эрэмбэ, тайлбарлагдсан корреляцийн үзүүлэлтүүдэд тулгуурласан. Иймд өгүүллийн зорилго нь шинэ статистик коэффициент тооцохоос илүүтэй, илэрсэн хамаарлыг онолын үндэслэлтэй тайлбарлахад оршино.

Хэмжилтийн шалгуур ба операціональчлалын тухайд, рационал эгоизмын шууд хэмжүүрийн анхдагч судалгаанд тусгайлан авч үзээгүй тул дараах индикаторуудыг ашиглав: (1) өөрийгөө үндсэрхэг гэж тодорхойлох хувь; (2) хошуучлагчид тавих үндэс угсаа, үзэл баримтлал, шашны шалгуур; (3) буддын шашин болон бусад шүтлэгийг дэмжих хувь; (4) улс төрийн байр суурийн ангилал; (5) өөрчлөлтийн хэв маягийн сонголт; (6) институт ба намын талаарх итгэлийн үзүүлэлт зэрэг болно. Эдгээрийг нийлмэл байдлаар тайлбарлаж рационал эгоизмын хамтын, ёс суртахууны, геополитикийн хэлбэрүүдийг ялган дараах хэмжилтийн индикатор ба аналитик тайлбарыг гарган танилцуулав (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хэмжилтийн индикатор ба аналитик тайлбар

| Шинжилгээний хэмжээс | Индикатор | Логикийн тайлбар | Өгөгдлийн эх сурвалж |
|-----------------------|---|--|---|
| Үндэсний ижилсэл | “Өөрийгөө үндсэрхэг” гэж тодорхойлсон хувь | Хамтын рационал эгоизм, “өргөтгөсөн би” | 2019 оны улс төрийн соёлын судалгаа |
| Ёс суртахууны шалгуур | Шашин хамаарах/хамаарахгүй гэсэн байр суурь | Ёс суртахууны соёлын капитал | 2024 оны хошуучлалын судалгаа |
| Хошуучлалын сонголт | Үндэс угсаа, үзэл баримтлал, шашны шалгуур | Хошуучлагчийн найдвартай байдлын индикатор | 2024 оны хошуучлалын судалгаа |
| Оролцооны хэв маяг | Сонирхогч, шүүмжлэгч, дэмжигч, үл сонирхогч | Ашиг, итгэл, зай барилтын хэлбэр | 2024 оны хошуучлалын судалгаа |
| Өөрчлөлтийн хандлага | Реформист, революционист, консерватив | Эрсдэл ба тогтвортой байдлын тооцоолол | 2024 оны хошуучлалын судалгаа |
| Геополитикийн түвшин | Гуравдагч хөрш, тусгаар тогтнол, баялгийн менежмент | Улсын түвшний рационал эгоизм | Бүлгийн болон чанарын судалгааны үр дүн |

Тэмдэглэл. Хүснэгтэд рационал эгоизмын далд хувьсагчийг эмпирик индикаторуудаар операциональчлал хийсэн логикийг нэгтгэн үзүүлэв.

Арга зүйн хувьд, энэхүү өгүүлэл нь өөр өөр хугацаанд хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн тайлбарлахдаа операциональчлалыг тодорхой болгож, рационал эгоизмыг орлох индикаторуудаар тайлбарласанаар арга зүйн ач холбогдолтой. Хэдийгээр анхдагч микро-өгөгдөлгүй нөхцөлд шалтгаант статистик шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал боловч хувь хэмжээ, эрэмбэ, тайлбарлагдсан корреляцийн үзүүлэлтүүдийг онолын загвартай холбосноор хоёрдогч өгөгдлийн аналитик үнэ

цэнийг өсгөж болно гэдгийг эл өгүүлэл харуулна. *Өгүүллийн шинэлэг тал нь* Монголын кейсийг дотоод улс төрийн хүрээнээс давуулан геополитикийн логиктой холбосонд оршино. Үндэсний үзэл, шашны үнэт зүйлсийг зөвхөн дотоод соёлын асуудал гэхээсээ илүүтэй жижиг улсын аюулгүй байдал, гаднын нөлөө, стратегийн тэнцвэрийн хүрээнд авч үзсэнээрээ нийгэм-улс төрийн судалгаанд олон улсын харилцааны өгөгдлийг холбох боломжийг нээж буйгаар онцлог.

Монголын нийгэм, улс төр дэх рационал эгоизмын илрэл

Монгол Улсын хувьд рационал эгоизм нь үндэсний оршин тогтнох стратеги болон иргэдийн нийгмийн оролцооны хэлбэрт хүчтэй ажиглагддаг бөгөөд үүнийг дараах байдлаар тоймлон илэрхийлж байна.

Геополитикийн рационал эгоизм буюу “гуравдагч хөрш”-ийн бодлого: Монгол Улс хоёр том гүрний дунд оршиж буйгаа “ухаалаг”-аар тооцоолж, өөрийн тусгаар тогтнолыг хамгаалахын тулд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлж, түүний хүрээнд бусад улс орнуудтай чөлөөтэй харьцахыг эрхэмлэдэг. Энэ нь зөвхөн дипломат харилцаа биш, харин үндэсний аюулгүй байдлаа хангахын тулд дэлхийн бусад тоглогчдын ашиг сонирхлыг Монголтой холбож буй рационал алхам буюу «бидний аюулгүй байдал бол тэдний ашиг сонирхол» гэсэн томъёоллыг чухалчилдаг хэмээн үзэж болох юм. Тодруулбал, Монгол Улсын геополитикийн байрлал нь рационал эгоизмын улсын түвшний тайлбарыг шаарддаг. Хоёр том гүрний дунд орших жижиг улс тусгаар тогтнолоо хадгалах, эдийн засгийн хараат байдлыг бууруулах, олон талт аюулгүй байдлын сүлжээ бий болгох шаардлагатай тулгардаг. Энэ нөхцөлд гуравдагч хөршийн бодлого нь “романтик” дипломат уриа бус, харин эмзэг орчныг тэнцвэржүүлэх рационал улсын эгоизмын бодлого юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс бусад том, дунд хүчнүүдийн ашиг сонирхлыг өөрийн тогтвортой байдалтай холбох замаар аюулгүй байдлаа өргөтгөдөг. Үндэсний үзэл энэ түвшинд зөвхөн соёлын бахархал биш,

харин гадаад орчны дарамтыг дотоод нэгдэл болгон хөрвүүлэх сэтгэлзүй-улс төрийн механизм болж байна. Ийм учраас иргэдийн дунд үндэсний ижилслийн шалгуур өндөр байх нь геополитикийн эрсдэлийг соёлын хэлээр дотоодчлон ойлгож буйн илрэл гэж тайлбарлаж болно. Нэг үгээр, жижиг улс өөрийн түүх, соёл, шашны өвийг стратегийн нөөц болгон ашиглах нь рационал сонголтын нэг хэсэг юм.

Байгалийн баялаг ба “Баялгийн хараал”-ын эсрэг рационал сонголт: Баялгийн менежментийн тухай маргаан энэ хүрээнд шууд тайлбарлагдах боломжтой. Учир нь байгалийн баялгийг богино хугацааны бэлэн мөнгө, халамжийн хэрэгсэл болгох нь примитив эгоизмын хэлбэр мөн. Харин хуримтлал, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн хөрөнгө оруулалт руу чиглүүлэх нь урт хугацааны рационал эгоизмын илэрхийлэл юм. Үүнтэй адил авлига нь хувийн шууд ашиг мэт харагдавч нийгмийн институци, итгэлцэл, үндэсний хөгжлийн чадавхыг сулруулдаг тул үнэн хэрэгтээ рационал бус үйлдэл болдог. Энэ үүднээс монголчуудын дундах байгалийн баялгийн тухай маргааныг рационал эгоизмын үүднээс тайлбарлал: (i) богино хэрэгцээг хангавч ирээдүйн эдийн засгийг сүйрүүлнэ; (ii) урт хугацааны (рационал) эгоизм буюу баялгийн санд хуримтлал үүсгэх, дэд бүтэц барихыг дэмжих. үүднээс иргэд «Би өнөөдөр 100 мянган төгрөг авснаас, маргааш чанартай зам, эмнэлэгтэй байх нь миний амьдралын чанарт

илүү тустай» гэдгийг ойлгох нь рационал эгоизм Монголд төлөвших үйл явцын илрэл юм.

Авлига ба примитив (түүхэн) эгоизмын зөрчил: Монголын нийгмийн хамгийн том сорилт бол “примитив эгоизм” (зөвхөн өөртөө, шууд ашиг олох) ба “рационал эгоизм”-ын зөрчил юм. Угтаа авлига авч буй албан тушаалтан нь өөртөө ашиг олж байгаа мэт боловч, үнэндээ өөрийн амьдарч буй нийгмийн систем (боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдал)-ийг нурааж байгаа учраас энэ нь рационал бус үйлдлийн үндсэн аргумент юм. Нэг үгээр бол, авлигын мөнгөөрөө гадаадад эмчлүүлэх шаардлагатай болж байгаа нь дотоодын системээ нураасны л үр дагавар гэж болно.

Шашны нөлөө буюу уламжлалт ёс зүй ба итгэлцэл: Шашны хүчин зүйл геополитикийн кейст хоёрдмол үүрэгтэй. Нэг талаас уламжлалт буддизм нь түүхэн ой санамж, соёлын залгамж чанар, дотоод ёс суртахууны хяналтыг бэхжүүлж, нийгмийн эв нэгдэлд эерэг нөлөө үзүүлж болно. Нөгөө талаас шашны ил тод бус санхүүжилт, гаднын сүлжээ, хэт туйлширсан нөлөөлөл нь эмзэг орчинд улс төрийн болон

үнэт зүйн нэвтрэлтийн сувгийг нээж болзошгүй. Иймээс шашныг дэмжих эсэх асуудлыг зөвхөн “уламжлал - шинэчлэл” гэсэн хоёр туйлт сөргөлдөөнөөр бус, “үндэсний соёлын тогтвортой байдал - гаднын нөлөөллийн эрсдэл - институцийн ил тод байдал” гэсэн гурвалсан хүрээнд авч үзэх нь илүү оновчтой байж болох юм. Энэ агуулгаараа Монгол дахь буддын болон бусад шашны сэргэлтийг нийгмийн “зохицуулагч” хэмээн харвал төрийн хууль хүрч ажиллах боломжгүй газар шашны “үйлийн үр” (карма) болон ёс зүйн сургааль нь хүмүүсийн харилцааг зохицуулж, бие биенээ хуурахгүй байх (рационал итгэлцэл) үндсийг бүрдүүлдэг. Энэ нь нийгмийн зөрчлийг багасгаж, хамтын амьдралыг “хямд” (цагдаа, шүүхийн зардал багатай) болгодог. Үүнээс үзвэл, монголын улс төрийн төлөвшил нь примитив эгоизмоос (*амин хувийн богино ашиг*) рационал эгоизм руу (*үндэсний эрх ашигт суурилсан хувийн ашиг*) шилжих шилжилт дээр тогтож буйн илрэл төдийгүй үндэсний үзэл, шашин нь энэхүү шилжилтийг хурдасгах, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэх соёлын капитал болж байна.

3. Судалгааны үр дүн

Дурдан буй сэдвийн хүрээнд ашиглаж буй судалгааны анхдагч эх сурвалж нь Монгол Улсын ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” (2017-2019), “Улс төрийн харилцаан дахь улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө” (2022-2024) суурь судалгааны тоон болон чанарын судалгааны үр дүнгүүдэд боловсруулалт хийж гаргасан болно. Түүнчлэн ОХУ-ын Шинжлэх ухааны сантай хамтарсан “Орос, Монгол дахь уламжлалт буддизм, шашны дараах болон орчин үеийн нийгэм-улс төрийн үйл явц” (2024-2026) төслийн хүрээнд хийгдсэн судалгааны завсрын үр дүн зэргийг тус тус ашиглав.

Дурдсан судалгаануудын үр дүнгээр үндэсний үзэл бол рационал эгоизмын хамтын хэлбэр бөгөөд үүнийг гол төлөв хувь хүний ашгаас дээгүүр тавигддаг “золиослол” мэтээр

задлан тайлбарладаг. Гэсэн хэдий ч рационал эгоизмын үүднээс авч үзвэл энэ нь “хамтын аминч үзэл”-ийн хамгийн боловсронгуй хэлбэр юм. Тодруулбал, үндэстэн бол “өргөтгөсөн би” (*extended self*) бөгөөд рационал эгоист хүн өөрийнхөө сайн сайхан байдлыг зөвхөн өнөөдрөөр бус, ирээдүйтэйгээ холбон үздэг. Тэрээр ганцаараа байснаас нэгдмэл хэл, соёл, хууль дүрэм бүхий “үндэстэн” хэмээх том бүлгийн гишүүн байх нь өөрт нь илүү ашигтай гэдгийг тооцоолдог. Үндэстний амжилт нь тухайн иргэний амжилт гаргах боломжийг (инфраструктур, боловсрол, эрүүл мэнд) нэмэгдүүлдэг учраас үндэсний эрх ашгийг хамгаалах нь эцсийн дүндээ өөрийгөө хамгаалж буй хэрэг юм. Чингэхээр “өргөтгөсөн би” хэмээх ойлголт нь анх сэтгэл судлал, маркетингийн шинжлэх ухаанд (Рассел Белк) үүссэн боловч улс төр, үндэсний үзлийн онолд маш хүчтэй байр суурь эзэлдэг. Энэ нь хувь хүн өөрийн гэр бүл, үндэстэн, соёлоо өөрийн нэг хэсэг (“минийх”) гэж хүлээн авч, тэдний төлөөх

үйлдлийг өөрийнхөө төлөөх үйлдэлтэй адил түвшинд авч үзэхийг хэлж буй хэрэг мөн. Үүнийг дараах судлаачдын дэвшүүлсэн онол, судалгааны үр дүнгээр тайлбарлаж болох юм.

Тухайлбал, Рассел Белк сэтгэлзүйн үндэслэл хэмээх нэр томъёог шинжлэх ухаанд оруулж ирсэн гол төлөөлөгч бөгөөд тэрээр *«Бид өөрсдийн эзэмшиж буй зүйлс, харьяалагдаж буй бүлэг, гэр бүл болон үндэстнээ 'өргөтгөсөн би'-гийнхээ хэсэг гэж үздэг. Улмаар эдгээр зүйлсийн амжилт нь бидний амжилт, эдгээрт учрах аюул нь бидэнд ирж буй аюул мэтээр мэдрэгддэг»* (Russell W. Belk, 1988) хэмээн илэрхийлсэн байдаг. Үүнийг үндэстнийг “өөрийн” гэж үзэх нь рационал эгоизмын үүднээс *«Миний үндэстэн хүчирхэг байх нь миний 'би' хүчирхэг байхын нөхцөл»* гэсэн тооцоолол хэмээн тайлбарлаж болно. Харин Пьер ван ден Берге үндэстнийг социобиологийн өнцөгөөр буюу “Өргөтгөсөн төрөл төрөгсөд” (*extended kinship*) хэмээн үзсэн. Тэрбээр *«Үндэсний үзэл бол угтаа 'өргөтгөсөн нэпотизм' (төрөл садангаа дэмжих үзэл) хэмээн тодорхойлсон. Нэг үгээр бол хүн өөртэйгөө ижил хэл, соёл, гарал үүсэлтэй бүлгийг (үндэстнээ) дэмжих нь өөрийнхөө генийг болон ирээдүйг хамгаалж буй рационал үйлдэл мөн.»* (Van den Berghe, 1981) хэмээх санааг дэвшүүлсэн. Энэ нь *«Би яагаад бусад үндэстнээс илүү өөрийн үндэстэндээ анхаарах ёстой вэ?»* гэдэгт рационал хариултыг өгч буй хэрэг.

Харин Яэль Тамир үндэстнийг хувь хүний сонголтын хүрээ гэдэг талаас буюу *«үндэстэн бол хувь хүний өөрийгөө илэрхийлэх, өөрийнхөө зорилгод хүрэхэд нь тусалдаг 'соёлын хүрээ' юм. Тиймээс үндэстнээ хамгаалах нь хувь хүн өөрийнхөө сонголт хийх боломжит орчныг хамгаалж буй хэрэг»* (Yael Tamir, *Liberal Nationalism*, 1993) мөн хэмээх либерал национализмын үүднээс тайлбарласан байдаг. Харин Теодор Рузвельт *«Рационал эгоизмын үүднээс авч үзвэл үндэсний үзэл нь сохор туйлширал биш, харин Рассел Белкийн тодорхойлсон 'Өргөтгөсөн би' (extended self)-гийн илрэл мөн. Тэгэхээр хүн өөрийнхөө аюулгүй байдал, нэр хүнд, эдийн засгийн боломжийг үндэстнийхээ ирээдүйтэй шууд холбон үзэх*

замаар үндэсний эрх ашгийг нэгдүгээрт тавих нь хувь хүний өөрийнхөө төлөө хийж буй ухаалаг (рационал) сонголт» (Fukuyama F, *The Origins of Political Order*, 2011) хэмээн томъёолсон. Энэ нь эх орондоо хайртай байна гэдэг нь өөртөө болон үр хүүхэддээ хайртай байхын нэг хэлбэр бөгөөд хүн эх орноосоо тусдаа цэцэглэн хөгжих боломжгүй гэсэн санааг илэрхийлсэн яюдал юм. Угтаа хувь хүнийг үндэстэнтэй нь нэгдмэл гэж үзэж буй явдал бөгөөд үүнийг улс төрийн сэтгэлгээний жишээ гэж үзэж болох юм. Түүнчлэн Алексис де Токвиллийн дэвшүүлсэн *“ухаалгаар ойлгосон хувийн ашиг сонирхол”* бол үндэсний үзэл болон иргэний нийгмийн харилцааг тайлбарлахад маш тохиромжтой санаа юм. Түүнийхээр бол *«Америкчууд бусдад туслахдаа үүнийг зөвхөн сайн санааны үйлс гэж хардаггүй, харин ухаалгаар ойлгосон хувийн ашиг сонирхол (self-interest rightly understood) гэж үздэг. Тэгэхээр бусдад туслах нь өөрсдийнх нь амьдарч буй нийгмийг илүү аюулгүй, цэцэглэн хөгжих суурь болгодог»* ажээ (Alexis de Tocquille, 1835). Тэгэхээр үндэсний үзэл бол зүгээр нэг хийсвэр хайр биш, харин эх орноо хөгжүүлэх нь эцсийн дүндээ “надад ашигтай” гэсэн ухаалаг тооцоолол болохыг эндээс харж болно.

Улс төр судлаач Томас Гоббсын хэлснээр хүмүүс аюулгүй байдлын төлөө ‘Нийгмийн гэрээ’ (Thomas Hobbes, 1651) байгуулдаг. Тиймээс үндэсний үзэл нь энэхүү гэрээний сэтгэлзүйн “цавуу” болж өгдөг. Жишээлбэл, иргэн хүн татвар төлөх эсвэл цэргийн алба хаах нь шууд угтаараа “хохирол” мэт боловч, үүний үр дүнд бий болох тусгаар тогтнол, аюулгүй орчин зэрэг нь тухайн хүний хувийн өмч, амь насанд хүрэх эрсдэлийг бууруулдагаараа аюулгүй байдлын рационал тооцоолол хэмээн үзэж болно. Энэ агуулгаараа үндэсний үзэл нь дотоодын зах зээлийг хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих замаар иргэн бүрийн орлогын эх үүсвэрийг тогтвортой байлгах зорилготой эдийн засгийн прагматизм гэж болно. Үүнийг рационал эгоизмын үүднээс тайлбарлавал, үндэсний хэлээрээ ойлголцох нь харилцааны зардлыг (transaction costs) бууруулаад (Coase R.H, 1937) зогсохгүй, үндэсний нэгдмэл үнэт зүйлс нь бизнес

эрхлэгчдийн хоорондын итгэлцлийг нэмэгдүүлдэг ач тусгай.

Харин прагматик эх оронч үзлийн онолоор “Эх оронч байна” гэдэг нь сохроор туйлшрах биш, харин *«Би эх орондоо хэрэгтэй хүн байж, эх орон минь надад хэрэгтэй орчин байх»* (Fukuyama F, Trust: The Social Virtues and the Creation of Prosperity, 1995) гэсэн харилцан ашигтай (win-win) зарчим юм. Нэг үгээр үндэстэн доройтвол хувь хүний боломж хязгаарлагдахыг рационал эгоист маш сайн ойлгодог гэсэн үг.

Дээр дурдсан онолын судалгааны үр дүнгээс, ард түмний үзэл хандлагын хүрээн дэх улс төр, нийгмийн хөгжлийн үйл явцад өрнөсөн өөрчлөлт шинэчлэл, ойлголт болоод сорилт бэрхшээл, боломж зэргийг үндэстнийх нь сэтгэлгээний үзэл, хандлагыг судлан таних нь зүй ёсны хэрэг хэмээн үзэх нь зүйтэй. Энэ агуулгаар өнөөгийн монголчуудын улс төрийн үзэл хандлага тэр тусмаа монголчуудын үндэсний үзлийн талаарх мэдлэг ухагдахууны бүтээц хийгээд түүнээс улбаалсан харилцааны төвшин дэх нөхцөл байдлыг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Тухайлбал, Монгол Улс дахь улс төрийн соёлын төлөвшлийн үйл явцыг тусгайлан судлах ад улс төрийн соёлын хүрээнд шийдвэрлэж хариу өгвөл зохих олон асуудал хуримтлагдсан нь илэрсэн. Үүний нэг илрэл бол монголчуудын уламжлалт нүүдлийн соёл нь суурин соёлын хүчтэй түрэлтэнд орж, нийслэл Улаанбаатар хотдоо хүн амын бараг тал хувь нь ажиллаж амьдарсаар буй өнөөгийн улс төрийн хандлага, үндэсний үзлийн талаарх орчин үеийн монголчуудын сэтгэлгээний өөрчлөлт нь хувьслын сонирхолтой үедээ ороод тодорхой хугацаа өнгөрч буй. Энэ үүднээсээ монголчуудын үндэсний үзэлд гарч буй өөрчлөлт, иргэнлиг байдлын талаарх сонирхолтой дүр зураг ажиглагдсныг дараах байдлаар хураангуйлан танилцуулж болох юм.


“Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага” сэдэвт судалгаагаар

монголчуудын үндэсний үзлийн талаарх ойлголтыг судалахад (УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, 2019) судалгаанд оролцогчдын 54.5 хувь нь “*өөрийгөө үндсэрхэг үзэлтэй*” гэж үзсэн нь хувь хүний болон хамтын ашиг сонирхлыг хамгаалах нэг хэлбэр болох нь ажиглагдаж байна. Тус судалгаагаар нийтлэг илэрсэн дараах тодорхой илэрхийлэмжүүд болох “*монгол хүний удмын сан*”, “*монгол цусаа цэвэр ариун байлгах ёстой*” гэсэн хандлагууд нь тухайн бүлэг өөрийн генийн сан, соёлын онцлогийг гадны нөлөөнөөс хамгаалж, ирээдүйд оршин тогтнох баталгаагаа хангах гэсэн рационал тооцооллыг илэрхийлэхийн зэрэгцээ өөрийгөө бусдаас ялгарах онцлогтой гэж үзэх эгоизмын нэг хэлбэр гэж болно. Тухайлбал, монголчуудын үндэсний үзлийн талаарх ойлголт, үндсэрхэг үзэлтэй эсэх талаар судалгаанд¹ хамрагдсан хот, хөдөөгийн нийт иргэдийн хариултаас үзвэл, респондентуудын «*өөрийгөө үндсэрхэг үзэлтэй*» (54.5%), «*өөртөө үндсэрхэг үзэл огт байдаггүй*» (9.4%), «*нэг их үндсэрхэг биш*» (32.8%) хэмээн хариулснаас үзэхэд хот хөдөөгийн иргэдийн хооронд үндэсний үзлийн талаарх зарчмын зөрүүтэй ялгаа төдийлэн мэдэгдэх өөрчлөлт байхгүй. Тодруулбал, судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү хувь нь «*өөрийгөө үндсэрхэг үзэлтэй*» гэж эргэлзээгүй хариулсан бол, гурван хүн тутмын нэг нь «*их биш ч гэсэн үндсэрхэг үзэл*»-ийг хүлээн зөвшөөрч буй байдал гэж болно. Энэ тоон зураглал нь үндэсний үзэл Монголын нийтийн ухамсарт давамгайл хэвээр байгааг харуулахын зэрэгцээ туйлширсан биш, харин шаталсан, прагматик агуулгатай байж болохыг илтгэнэ (Зураг 1). Өөрөөр хэлбэл, өөрийгөө үндсэрхэг гэж тодорхойлсон бүх иргэн этноцентризм дэмжсэн гэсэн үг биш; харин үндэсний ашиг сонирхлыг аюулгүй байдал, соёл, нөөцийн хамгаалалттай холбон ойлгож буй өргөн хүрээний өөрийгөө илэрхийлэл гэж тайлбарлаж болно.

¹ ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбараас «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» суурь судалгааны төслийн ажлыг 2017-2019 онд хэрэгжүүлж, төслийн хүрээнд «Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага» олон нийгтийн санал асуулгыг Улаанбаатар хотын 6 дүүрэг болон Дундговь, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Ховд аймгийн 1000 орчим иргэдийг хамруулсан.



Зураг 1. Судалгаанд хамрагсдын үндсэрхэг үзэлтэй эсэх (хувиар)



Эх сурвалж: Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага. ОНСБ-ын судалгааны тайлан. УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2019.

Дээрхээс үзвэл «уламжлал үгүй бол шинэчлэл үгүй, шинэчлэл үгүй бол хөгжил үгүй» хэмээхтэй утга нэгэн адил ёс суртахууныг умартсан нийгэм бол шударга ёс, үүрэг хариуцлага, эрх чөлөөт байдал, сайн сайхнаас ангид дэндүү харанхуй нийгэм болох талтай учир (Оюунгэрэл Д, 2018) уламжлал, заншил гэдэг нийгэмд тэр дундаа дорнын соёлтой монголчуудын дунд хот, хөдөөгийн гэлтгүй нийгмийн амьдралд тавигдаж байсан ёс суртахууны шаардлага, алдаа дутагдлыг арилган засах арга барил, хариуцлагын хэр хэмжээ зэргийг нарийвчлан шинжилсэн хойч үеийнхээ боловсрол хүмүүжилд анхаарлаа хандуулах ёстойг харуулж буй. Энэ нь төгөлдөржилт бол нэгдэн найрссан шинэ төлөв байдал нь өмнөх хуучин төлөв байдлаа үгүйсгэн илүү дээр шатанд хүрэх агаад энэ мэтчилэн хөгжил ороомог байдлаар үргэлжлэх тул иргэд уламжлал, заншлаа нийгмийн амьдралын салбар бүр дотооддоо салаалан мөчирлөж (Даш-Ёндон Б, 2017) бөөнөөсөө задран дэлгэрдэгтэй адил нийгмийн хөгжлийн нэг үзүүлэлт, нөгөө өрөөсгөл үзүүлэлттэйгээ уялдаатай, бие биенээ дэмжсэн зохицол гэж болно. Үүнээс гадна санаа сэтгэлийн сайжрал, зөв буруугийн явдлаар нь хүнийг дээш нь дэвшүүлж, доош нь шилжүүлэх тухай бүр ардчилсан үзэл санааны үр хөврөл бүхий иргэний гайхамшигт санааг ихэд өргөн дуулсан нь нэг үгээр хэлбэл, аливаа асуудалд цэгц шударга ханддаг, билэг ухаан төгс, ухаалаг монгол түшмэлийн улс гэр, хошуу нутгаа хэрхэн

авч явсан хойчид сургамжтай, холд дурсгалтай үлгэр лугаа зүйрлэн монгол үндэсний соёлыг монголын тусгаар тогтнолын нэгэн баталгаа болгон хөгжүүлж ирсэн, холч ухаан цэцэн билэгт чанар мөн болохыг учирласан (Хүрэлбаатар Л, 1996) нь бий. Өдгөө бидний «мод хүртэл ургаж мөхдөг, хүн бас төрж үхдэг»-ийн адилаар нэгэнтээ дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн «Энэ олон мод, энэ ой мод, мод заримдаа хүн шиг алаг эрээн амьдралын аливаа тавиланг амсаж буй» (Явуухулан Б, 1985) хэмээн шүлэглэсэн нь монголчууд эртнээс нааш байгаль дэлхийгээ хайрлан хүндэлж, түүнийг бишрэн дээдэлж ирсний баталгаа мөн. Нөгөөтээгүүр, нийгэм болоод техник технологи хурдацтай хөгжих тусам нутгийн иргэдийн байгалиа хайрлах хандлага буурч байгаа нь нэг талаас иргэдийн ухамсрын төвшин, нөгөө талаас нийгмийн бусад хүчин зүйлс болох ядуурал, уламжлалт соёл, үнэт зүйлс суларч буйтай холбоотой. Үүнээс үндэсний үзэл бол бүх хувь хүнийг үгүйсгэдэг хийсвэр үзэл биш, харин хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах 'хамтын хамгаалалтын систем' бүхий рационал эгоист хүн өөрийнхөө төлөө үндэстнээ дээдэлдэг зарчим хэмээн дүгнэж болох юм.

Үүнээс улбаалан монголчуудын улс төрийн харилцаан дахь улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө сэдэвт (Хишигдаваа А, Цанжид А, Жаргал Ц, ба бусад, 2024) судалгаагаар² улс төрийн хошуучлагчийн


² ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбараас «Улс төрийн харилцаан дахь улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө» суурь судалгааны төслийн ажлыг 2022-2024 онд хэрэгжүүлж, төслийн хүрээнд «Улс төрийн хошуучлалын өнөөгийн байдал, төлөв хандлага» олон нийгтийн санал асуулгыг Улаанбаатар хотын 6 дүүрэг болон Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Баянхонгор, Ховд аймгийн 1100 орчим иргэдийг хамруулсан..

хувьд нийгмийн байдлын үзүүлэлтэд корреляцийн шинжилгээ хийж зэрэглэл тооцон үзвэл: 1-рт улс төр ба үндэс угсаа 76.7 хувиар өндөр байна. Энэ нь үндэс угсаа нь монголчуудын улс төрийн хошуучлалын сонголтод хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл гэдгийг харуулаад зогсохгүй үндэсний үзэл ба рационал эгоизм нь салшгүй холбоотойг баталж байна. Үүний зэрэгцээ, шашин улс төрийн харилцаанд огт хамаарахгүй гэсэн үзэл бодлыг илэрхийлсэн хүмүүс (1.7%) байсан нь рационал байдлаар шашныг улс төрийн үйл явцаас тусгаарлахыг эрмэлзэж буйг хэрэг юм (Зураг 2). Эдгээр үзүүлэлтийн дараалал нь иргэдийн сонголтод үндэсний ижилсэл хамгийн хүчтэй, үзэл баримтлал дараагийн түвшинд, шашин дунд түвшний шалгуур болж байгааг харуулж байна. Энэ нь шашин улс төрийн гол түлхүүр биш боловч ёс суртахууны шинж чанар, итгэл

даах байдал, уламжлалтай нийцэх байдлыг үнэлэхэд нөлөөлсөөр буйг илтгэнэ.

Дээрх шинжилгээнээс улс төрийн хошуучлагчийн баримтлал 58 хувьтай бөгөөд 2 дахь чухал хүчин зүйлд тооцогдож байгаагаас гадна хошуучлагчийн үзэл баримтлалын хувьд шашин шүтлэггүй байдал 20.3 буюу корреляцийн хамаарал сул байгааг илэрхийлж байна. Түүнчлэн шашин улс төрийн үзэл баримтлалд нөлөөлдөггүй гэсэн байр сууринаас хандах нь 15.9 корреляциар буюу хамаарал багатайг харуулж байна. Харин улс төр ба жендэрийн хувьд 55.2 корреляциар 3-р зэрэглэлд эрэмбэлэгдэж байна. Энэ нь улс төр дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буйтай холбоотой бөгөөд шүтлэггүй байдал 31.3 корреляцийн хамаарлын утга сулавтар байгааг илэрхийлэв. Улс төр ба жендэрт шашин шүтлэгийн хамаарал байхгүй болох нь 4.5 корреляциар хэмжигдэж байна.

Зураг 2. Шашин улс төрийн хошуучлагчид чухалд тооцогдох хүчин зүйлсийн корреляцийн шинжилгээ (хувиар)




Эх сурвалж: Монгол дахь улс төрийн хошуучлалын өнөөгийн байдал, төлөв хандлага. ОНСБ-ын судалгааны тайлан. УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2024.

Зурагт харуулсан 4-р зэрэглэлд улс төр ба шашин нь 50.0 корреляцийн хэмжээгээр хамаарал дунд түвшинд багтаж байна. Улс төр ба шашинд шүтлэггүй байдал 16.7 корреляциар сул хамааралтай байгааг харуулж байна. Бусад

(фэнгшү, газар нутаг, ус, эцэг эхээ асран хайрлахуй гм) шүтдэг зүйлсэд 16.6 корреляцийн үзүүлэлттэйгээр улс төрд оролцдог нь энэхүү шинжилгээгээр илэрсэн (Зураг 3).

Зураг 3. Улс төр дэх шашны нөлөөлөл



Эх сурвалж: Монгол дахь улс төрийн хошуучлалын өнөөгийн байдал, төлөв хандлага. ОНСБ-ын судалгааны тайлан. УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2024.

Дурдсан судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд буддын шүтлэгтэй байхыг дэмжигсэд 45.7 хувь, бөө мөргөлийн шүтлэгтэй 4.0 хувь, тэнгэр, байгаль эхийг шүтэгсэд 3.0 хувь, христэд итгэлтэй байхыг дэмждэг 2.2 хувь, исламын шашныг 0.8 хувь дэмжсэн үзүүлэлт нь буддизм Монголын нийтийн сэтгэлгээнд уламжлал, түүхэн тасралтгүй байдал, үндэсний онцлогийн тэмдэглэгээ хэвээр байгааг харуулна. Гэхдээ энэ нь шууд шашинжсан улс төрийн хүсэлт биш, гагцхүү “манай” гэх соёлын ойр байдлыг илтгэж буй учраас үүнийг ёс суртахууны соёлын капиталын нөөц гэж тайлбарлах нь зөв. Ташрамд дурдахад, судалгаанд оролцогчид гол төлөв гадны бус

өөрсдийн хэмээж буй буддын шашинг дэмжих хандлага гаргаж буй нь судалгааны явцад илт байв. Үүнийг чанарын ярилцлагаар илэрсэн шашны хүчин зүйлээр дэлгэрүүлэн дор шигтгэвэл дараах илэрхийлэмж нийтлэг ажиглагдсан. Тухайлбал, уламжлалт буддын шашин болон бөө мөргөл монголчуудын өдөр тутмын амьдрал зан үйлд гүн бат шингэж түүнийгээ дагасаар байгаа хэдий ч нийгмийн хөгжил, хувь хүний сэтгэлгээний өөрчлөлтөөс шалтгаалан шашин шүтлэгт ялгаатай байдал илэрч болохыг үгүйсгээгүй. Гэсэн хэдий ч уламжлалаа гээхгүй байхыг илүүд үзэх хандлага байсаар буйг судалгаанд оролцогчдын илэрхийллээс харж болох юм.

....Манай монголчууд эрт дээр үеэс өвлөгдөж ирсэн буддын гүн ухааныг өнөөг болтол уламжилж ирсэн. Шашин номын хувьд буддизмын хүн байх нь улс төрд томоохон ач холбогдолтой. Ядаж л үүх, түүхээ мэдэх юм даа.

....Ер нь бол христ, ислам гэсний хэрэггүй ээ. Гадны улс орны шашинтай хүн улс орныг удирдаж, чиглүүлж явахад бэрх, бөө мөргөлийн хувьд бас манайх л даа “тэнгэр язгуурт монгол” гээд байдаг биз дээ.

....Манай улс төрд бөө мөргөлийн зан үйл их хатуу учраас хатуудах байх гэж боддог. Гэхдээ л христ, ислам энэ тэрээс хавьгүй дээр. Бөөгийн зан үйл тэгээд хүнийг бас өөрсдийн хэвэндээ оруулаад донтуулсан юм шиг өөрөөсөө хараат байлгаад байдаг нь таалагддаггүй. Буддизмын шашин их зөөлөн талдаа дотроо, сүсэглээд маань мэгзмээ уншаад явдаг. Лам, хуварга бол бас их хүчтэй шүү. Шашин төрд лам, хуваргын үүрэг оролцоо бол их байдаг байсан шүү.

Эх сурвалж: Монгол дахь улс төрийн хошуучлалын өнөөгийн байдал, төлөв хандлага. Чанарын судалгааны хэсгээс. УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2024.

Улс төр ба шашны хооронд 50.0 хувийн дунд түвшний хамаарал илэрсэн нь хоёр чухал утгатай. Нэгдүгээрт, шашин улс төрийн сонголтыг бүрэн тодорхойлогч хүчин зүйл биш; хэрэв тийм байсан бол үндэс угсаа болон үзэл баримтлалын үзүүлэлтээс давсан байх байв. Хоёрдугаарт, шашин бүрэн ач холбогдолгүй ч

биш; хэрэв тийм байсан бол хамаарал маш сул түвшинд буух ёстой байлаа. Иймээс шашин Монголын улс төрийн орчинд институцийн биш, харин ёс суртахууны болон бэлгэдлийн зуучлагч шинжтэй байна гэж дүгнэж болно. Энэхүү дунд түвшний хамаарлыг “ёс суртахууны соёлын капитал”-ын ойлголтоор тайлбарлавал илүү

оновчтой. Иргэд шашныг улс төрийн шууд хөтөлбөрөөс илүүтэйгээр хошуучлагчийн өөрийгөө хянах чадвар, нүгэл-буяны ойлголт, уламжлалд хамаарах байдал, итгэл даах шинжийн дохио гэж уншиж байна. Энэ нь ёс суртахууны хүлээлт улс төрийн шалгуурт хөрвөж буй хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, шашны индикатор нь итгэлцлийн орлуулга болж байгаа бөгөөд институцийн итгэл сул үед ийм дохио улам чухал болдог.

Рационал эгоизмын үүднээс авч үзвэл, шашин болон уламжлалт ёс зүй нь нийгмийн гишүүдийн хоорондын “үл итгэлцлийн зардал” (*transaction costs*)-ыг (North D.C., 1990) бууруулахад чиглэсэн соёлын инженерчлэл юм. Энэ талаарх санааг улс төр судлаач Фрэнсис Фукуяма “Итгэлцэл: Нийгмийн сайн сайхан ба цэцэглэн хөгжил” (Fukuyama F, Trust: The Social Virtues and the Creation of Prosperity, 1995) бүтээлдээ нийгмийн гишүүдийн хоорондын итгэлцэл өндөр байх тусам эдийн засаг, улс төр нь илүү үр ашигтай ажилладаг болохыг нотолсон нь бий. Үүнийг рационал өнцөгөөс нь тайлбарлан үзэхүл: «Хэрэв би таныг “нүгэл хийхээс айдаг” эсвэл “ёс зүйтэй хүн” гэж итгэж байвал би тантай гэрээ байгуулахдаа хуульч, цагдаа, харуул хамгаалалтад зарцуулах мөнгөө хэмнэж чадна» хэмээсэн нь итгэлцэл бол хоёр талдаа ашигтай (win-win) учраас рационал эгоист хүн нийгэмдээ шашны эсвэл ёс зүйн хэм хэмжээ тогтсон байхыг дэмждэг гэсэн үг. Энэ нь итгэлцэл ба нийгмийн капитал нь хоорондоо салшгүй холбоотой болохыг илтгэнэ.

Харин Буддын шашны үндсэн сургааль болох “Үйлийн үр” (карма) нь рационал эгоизмын логиктой илүү сайн нийцдэг хэмээх утгаараа алсын хараатай эгоизмын дээд хэлбэр юм. Үүнийг дэлгэрүүлэн тайлбарлавал: «Би өнөөдөр бусдад тусалбал маргааши (эсвэл дараа төрөлд) надад сайн үр ирнэ» гэсэн сэтгэлгээ нь угтаа өөрийнхөө ирээдүйд хийж буй урт хугацааны хөрөнгө оруулалт юм. Энэ нь богино хугацааны ашгийн төлөө бусдыг хуурах “примитив эгоизм”-ыг хазаарлаж, илүү ухаалаг, нийгэмд тустай эгоизмыг төлөвшүүлдэг. Чингэхээр Монгол шиг газар нутаг том, хүн ам сийрэг, төрийн хяналт бүх цэгт хүрч ажиллахад хүндрэлтэй нийгэмд шашин нь “дотоод цагдаа”-

гийн үүргийг гүйцэтгэдэг буюу “зөөлөн хууль” гэж үзэж болох юм. Тодруулбал, хүмүүс төрийн шийтгэлээс айсандаа биш, харин өөрийнхөө дотоод үнэт зүйлд (шашны ёс зүйд) үнэнч байснаар нийгмийн дэг журмыг сахидаг гэсэн үг. Энэ нь төрийн зүгээс нийгмийг хянахад гарах зардлыг асар ихээр хэмнэдэг рационал механизм юм.

Монголын өнөөгийн нөхцөл байдалд монголчуудын уламжлалт “нүгэл, буян”-ы тухай ойлголт нь орчин үеийн бизнесийн этик, улс төрийн хариуцлагатай огтолцох ёстой. Хэрэв улс төрч хүн “нийтийн хөрөнгөөс хулгайлах нь миний нэр хүнд болон үр хүүхдийн ирээдүйд хортой” гэдгийг шашны эсвэл ёс зүйн үүднээс рационалиар ухамсарлавал энэ нь авлигын эсрэг хамгийн хүчтэй механизм болно. Тухайбал, Ф.Фукуямагийн тодорхойлсноор «Итгэлцэл бол нийгмийн амьдралыг илүү үр ашигтай болгодог 'тосолгооны материал' юм. Итгэлцэл өндөр байх тусам хамтын ажиллагааны зардал багасдаг» (Fukuyama F, Trust: The Social Virtues and the Creation of Prosperity, 1995) төдийгүй «шашин бол хүмүүсийг аминч үзлээс нь ангижруулдаг биш, харин тэдний аминч үзлийг илүү ухаалаг, нийгэмд хор багатай хэлбэрт шилжүүлдэг хүчин зүйл» (Alexis de Tocqueville, 1835) хэмээх Алексис де Токвиллийн дэвшүүлсэн санаатай дүйж буй юм.

Дээрх илэрхийллийг тоон судалгааны үр дүнгээр дэлгэрүүлэх замаар улс төрд оролцох оролцооны байр суурийг шашинтай харьцуулбал шашин шүтлэгийн хэлбэр бүрд улс төрийн сонирхогчын хувь өндөр байна. Тодруулбал, шашинтай харьцуулсан улс төрийн байр сууриас буддын шашинтай бүлэгт “сонирхогч” ангилал 54.7 хувь, христийн шашинтай бүлэгт 56.5 хувь, шүтлэггүй бүлэгт 48.0 хувь, “шашин хамааралгүй” гэсэн бүлэгт 45.6 хувь байгаа нь шашинтай байх эсэхээс үл хамааран улс төрийг анхаарч буй өргөн давхарга оршин байгааг харуулна (Хүснэгт 2). Тиймээс шашин улс төрийн сонирхлын цорын ганц тайлбарлагч биш бөгөөд харин улс төрийн үнэлгээний ёс суртахууны хүрээ, соёлын хэллэгийг өөрчилдөг гэж үзэх нь илүү зохистой. Үүнийг дараах хүснэгтээс дэлгэрэнгүй харж болох юм.

Хүснэгт 2. Улс төрийн байр суурийг шашин шүтлэгийн байдалтай харьцуулсан байдал

| № | Шашин шүтлэг | Сонирхогч | Шүүмжлэгч | Дэмжигч | Огт сонирхдоггүй | Бусад |
|---|-------------------|-----------|-----------|---------|------------------|-------|
| 1 | Будда | 54.7% | 11.4% | 14.8% | 16.8% | 2.3% |
| 2 | Бөө мөргөл | 40.5% | 21.4% | 21.4% | 16.7% | 0.0% |
| 3 | Тэнгэр шүтлэг | 40.6% | 21.9% | 12.5% | 18.8% | 6.3% |
| 4 | Христ | 56.5% | 13.0% | 13.0% | 8.7% | 8.7% |
| 5 | Ислам | 50.0% | 12.5% | 12.5% | 25.0% | 0.0% |
| 6 | Шүтлэггүй | 48.0% | 9.0% | 9.9% | 31.6% | 1.5% |
| 7 | Шашин хамааралгүй | 45.6% | 11.8% | 8.1% | 28.7% | 5.9% |
| 8 | Хариулж мэдэхгүй | 28.6% | 0.0% | 0.0% | 71.4% | 0.0% |


Эх сурвалж: Монгол дахь улс төрийн хошуучлалын өнөөгийн байдал, төлөв хандлага. ОНСБ-ын судалгааны тайлан. УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2024.

Иргэдийн зүгээс улс төрчдийн улс төрийн байр суурь нь будда, бөө мөргөлийн сүсэгтэй байхыг зөвтгөсөн оролцогчид 36.2 буюу $14.8 + 21.4 = 36.2$ хувийг эзэлж байна. Тэнгэр шүтлэгтэй байхыг чухалчилсан нь 21.4 хувь, христ итгэлтэй улс төрч байхыг чухалчилсан иргэд 13.0 хувь, исламын шашинтайг 12.5 хувь нь дэмжигч байр сууринаас ханддаг байна. Улс төрд шүүмжлэгч байр сууринаас хандагсад тогтмол буюу 11.4-21.9 хувьтай байгаа нь дээрх харьцуулалт (Хүснэгт 1)-аас харагдана. Шүтлэггүй болон шашин улс төрд нөлөөлөхгүй гэсэн өөрийн байр сууриа тодорхойлж мэдэхгүй иргэд улс төр дэх оролцоо сул бөгөөд сонирхдоггүй болохыг илтгэж буй явдал юм. Дээрх харьцуулалтыг ашиглан өнөөгийн сонгогчид ямар төрлийн хошуучлагч сонгож буйд хэв маягчлал үүсгэн түүнийг шашинтай харьцуулан үзвэл дараах сонирхолтой дүр зураг ажиглагдана. Улс төрийн хошуучлагчдын шинж чанараас үүсгэсэн хэв маягчлалыг шашинтай харьцуулсан үзүүлэлтээс бөө мөргөл болон уламжлалт буддын шашинг бүх төрөл (1-4)-ийн

сонгогчид тогтмол хувиар илэрхийлжээ. Нэгээс дөрөвдүгээр төрлийн сонгогчид шүтлэггүй, шашны оролцоогүй улс төрч байхыг чухалчилсан нь ойролцоо хувийг зааж тогтмол үзүүлэлттэй болохыг үүнээс харч болно (Зураг 4).

Энэхүү өгүүлэлд тодруулсан Монгол Улсад ямар төрлийн хэв маягийн хошуучлал тохирох талаар иргэдийн шүтдэг шашинтай харьцуулалтаас шашингүй үзлээр улс төрд хандахыг хүссэн иргэд реформист буюу шинэчлэгч байр сууринаас хандаж, улмаар эрс шинэчлэл рүү тэмүүлдэг улс төрч илүүтэй тохирно гэсэн байр сууринаас хандагсад нийт судалгаанд оролцогчдын 44.9 хувийг эзэлж байв. Монголд тогтсон янз бүрийн шашны урсгалаас шалтгаалан өөр өөрсдийн шашин шүтэх эрх чөлөөгөө эдлэхийн зэрэгцээ революционист (хувьсгалч) буюу өөр нийгэм рүү шилжихийг зөвтгөсөн иргэд 26.1 хувийг эзэлсэн нь судалгааны тоон мэдээлэлд боловсруулалт хийж үзэхэд илэрсэн юм. Энэ нь одоогийн тогтолцоог үр ашиггүй гэж рационалаар дүгнэж, өөрчлөлт хийх сэдлийг бий болгож буй хандлага юм.

Зураг 4. Сонгогчид ямар төрлийн хошуучлагч сонгож буйг шашинтай харьцуулсан хэв маягчлал



Тайлбар: **1-р төрлийн сонгогчид** (Нөхцөл байдлаас шалтгаалан шийдвэр гаргадаг, харилцан итгэлцэлд түшиглэдэг); **2-р төрлийн сонгогчид** (Оюунлаг, ардчилсан үзэл баримтлалтай, ард түмний хэрэгцээ шаардлагад тулгуурлан хариу үйлдэл үзүүлдэг); **3-р төрлийн сонгогчид** (Ард түмний хэрэгцээ шаардлагад тулгуурлан хариу үйлдэл үзүүлдэг, бусдыг уриалан чиглүүлж чаддаг, шинийг эрэлхийлсэн); **4-р төрлийн сонгогчид** (Харилцан итгэлцэлд түшиглэдэг, хүсэл тэмүүлэлдээ итгэдэг)

Харин консерватив (хуучинсаг) буюу одоогийн оршин байгаа нийгмийн тогтсон байдлыг хадгалахыг зорих явдал (24.6 хувь) байсаар байгаа нь уламжлалт үнэт зүйлсийг хамгаалах гэсэн эгоист хандлагын илрэл болно. Үүний шалтгаан нь хуучин нийгмээ хадгалан үлдээд бага зэргийн өөрчлөлтүүдийг оруулах ёстой гэсэн байр сууринаас хандах явдал судалгаанд оролцогчдын дунд байгааг илэрхийлж байна (Зураг 5). Үүнээс энэ төрлийн оролцогчид шашнаас хамаарч илүү консерватив

шинжийг агуулсан хэвээр байгааг илтгэнэ. Хошуучлалын хэв маягийн хувьд судалгаанд оролцогчдын 44.9 хувь реформист, 26.1 хувь революционист, 24.6 хувь консерватив хандлагыг дэмжсэн нь өнөөгийн Монголын улс төрийн орчинд эрс шинэчлэлийн эрэлт байгаа ч тогтвортой байдал, уламжлал, танил ёс суртахууны хүрээг орхих хүсэл бага хэвээр байгааг харуулна. Энэ бол рационал эгоизмын “эрсдэлтэй шинэчлэл - хамгаалалтын уламжлал” гэсэн хос логикийн илрэл юм.

Зураг 5. Шашин шүтлэгийн байдал ба улс төрийн хошуучлагчдын хэв маяг



Эх сурвалж: Монгол дахь улс төрийн хошуучлалын өнөөгийн байдал, төлөв хандлага. ОНСБ-ын судалгааны тайлан. УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2024.

Орчин үеийн Монголын нийгэм дэх хувь хүний зан төлөв, улс төрийн сонголт болон үндэсний ижилсэлд рационал сонголтын онол болон эгоизмын үзэл санаа хэрхэн нөлөөлж буйг дээр дурдсан судалгааны үр дүнд үндэслэн

монголчуудын улс төрийн институтэд итгэх итгэл, үндсэрхэг үзлийн прагматик шинж чанар болон улс төрийн хошуучлагчид тавих шашны шалгуурыг статистик хамаарлаар тайлбарлавал дараах сонирхолтой дүр зураг ажиглагдав. Нэг

үгээр бол, монголчуудын нийгэм улс төрийн чиг баримжаа дахь рационализм, эгоизм болон шашны хүчин зүйлсийн хамаарал дундаж төвшинд хэлбэлзэж байна. Үүнийг Р.Такерийн

онол болоод корреляцийн шинжилгээгээр улс төрийн лидерт тавих шалгуурыг дараах байдлаар эрэмбэлж болох юм (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Монголчуудын нийгэм-улс төрийн чиг баримжаа дахь рационализм, эгоизм болон шашны хүчин зүйлсийн хамаарал

| Хүчин зүйлс | Корреляцийн үзүүлэлт | Тайлбар |
|---------------------------|----------------------|--|
| Улс төр ба үндэс угсаа | 76.7% | Хамгийн хүчтэй хамаарал. Лидер нь үндэсний ижилсэлийн тээгч байх ёстой. |
| Улс төр ба үзэл баримтлал | 58.0% | Хоёр дахь чухал хүчин зүйл. Үзэл баримтлал нь төлөвшсөн тохиолдолд улс төр хариуцлагатай явагдана. |
| Улс төр ба шашин | 50.0% | Шашин нь лидерийн ёс суртахууныг илэрхийлэх “соёлын капитал” болох боломжтой. |

Монгол Улсад тохирох хошуучлалын хэв маягийг судалгаанд хамрагдсан иргэдийн шүтдэг шашинтай харьцуулахад буддын шашинтнуудын 45.7 хувь нь лидерийг нийгмийг чиглүүлэгч, ёс зүйтэй байхыг чухалчлах хандлага үлэмж байна. Дээр дурдсан ангилалд хамрагдсан 1-4 төрлийн сонгогчид (итгэлцэл, хэрэгцээ, хариу үйлдэлд тулгуурласан) шүтлэггүй байх эсвэл шашны оролцоогүй улс төрийг тогтмол дэмжиж байгаа нь либерал-секуляр рационализм төлөвшиж буйн илрэл болохыг дээрх хамаарлын шинжилгээ харуулж байна. Монголын нөхцөлд энэ нь “рационал эгоизм” буюу өөрийн угсаа гарвал, үндэс угсааг хамгаалах замаар хувийн аюулгүй байдлаа хангах хэлбэрээр илэрч байна. Энэ нь уламжлалт үнэт зүйлс, соёлын цэвэр ариун байдлыг хамгаалах гэсэн рационал эгоизмын хандлагыг үл харгалзан, хувь хүний аз жаргал, сайн сайхан байдлыг (индивидуалист эгоизм) дээдлэх хандлага нэмэгдэж буйг харуулж байна.

Өнөөгийн монголын нийгэм дэх буддын шашны төлөв байдлын хэрэгжилт, соёл-ахуйн нөлөөлөл, төрийн бодлого, геополитикийн эмзэглэл, цахимжилтын эрин дэх шашны үр нөлөөлөлд гарсан өөрчлөлтийг их дээд сургуулийн оюутнууд, хөдөө орон нутгийн холимог насны иргэд, хотын ажилтнуудын дунд зохион байгуулсан бүлгийн ярилцлага болон шинжээчдийн гүнзгийрүүлсэн ярилцлагын (УТЭЗС, 2025) илэрхийлэмжүүдэд тематик

шинжилгээ (thematic analysis)-ний арга зүйгээр кодчилж, бүлэг хоорондын консенсус/зөрүү, хот-хөдөө, нас/боловсролын ялгаа, хандлагыг тодорхойлов. Чингэхэд оролцогчид шашны талаарх нийтлэг зарчмын хүрээг “төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” (Үндсэн хууль, 1992) хэмээх Үндсэн хуулийн зарчмыг хүндлэн дээдэлж, улс төрийн хэлмэгдүүлэлтийн үед хамгийн их хохирол амссан бурханы шашныг нийтлэгээр дэмждэг боловч санхүү, татвар, ил тод байдлын практикийн сулрал, гаднын шашны “хутгалдал буюу хэт туйлшрал”-д санаа зовних байдал түгээмэл байгааг ийнхүү илэрсэн. Эдгээрийг задлан үзэхүл хувь хүн, шашны байгууллага, төр, гадны улсуудын шашны үйл ажиллагаа явуулдаг төвүүд, цахим платформуудын харилцан үйлдлийн механизмууд (норматив нийгэмшил, зан үйлийн үйлчилгээжилт, улс төрийн ашиглалт, дижитал зуучлал) онцгой нөлөөтэй болох нь ажиглагдсан. Энэ бүхнээс бодлогын цар хүрээг тодруулбал: **ёс суртахуун** → **итгэл** → **зан үйл** хэмээх дарааллаар иргэний боловсрол, цахим шашны үйлчилгээний ёс зүйн стандарт, шашны байгууллагуудын ил тод байдал, нийгмийн сэтгэл зүйн болон нийгмийн халамжийн түншлэл, геополитикийн эмзэг сэдвүүдэд тэнцвэртэй харилцааны зарчмыг илүүтэй баримтлах ёстойг илэрхийлсэн юм. Үүнээс үзэхэд, дурдсан судалгаанд оролцогчдын

дийлэнх нь монголчуудын уламжлалт зан үйл ахуй соёл нь бөө мөргөл, байгаль шүтлэг шингэсэн буддизмыг илүүтэй дүрсэлсэн байна. Энэхүү тематик шинжилгээгээр буддизмыг соёл-өв, ёс суртахууны сургааль, зан үйл, сэтгэлийн засал хэмээх талаас нь “ухамсартайгаар шинжлэх” философийн нэгдэл гэж ойлгодог хэв шинж нийтлэг илэрсэн. Нийгмийн сэтгэлзүй, ёс зүйн тогтвортой байдал, эв нэгдэлд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ мухар сүсэгт тулгуурласан арилжааны маягийн бодлогын нөлөөлөлд орох эрсдэл нэмэгдэх хандлага сүүлийн жилүүдэд гарах болсон нь зарим талаар санхүүгийн ил тод байдал шашны нийгэм, улс төрийн өнөөгийн байдлын сул талууд түгээмэл ажиглагдсаныг энд дурдах хэрэгтэй. Түүнчлэн төр-шашны харилцаанд секуляр зарчмыг хадгалах боловч олон нийтийн сайн сайхан байдлын чиглэлд зорилтот хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага давамгайлж байна. Тухайлбал, эмэгтэйчүүд сүсэгтний түвшинд идэвхтэй байр суурь эзэлдэг ч шашны байгууллагуудын удирдлага дахь эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй хязгаарлагдмал байдалтай байсаар байна. Хот, суурин газрын хувьд шашны олон урсгал зэрэгцэн орших боломж харьцангуй өндөр байгаа бөгөөд цахим платформоор дамжуулан бясалгал хийх, айлдвар сонсох, цахимаар шууд дамжуулалт (live) хийх зэрэг хандлагууд нилээд тархмал шинжтэй байна. Хэдийгээр энэ төрлийн үйл ажиллагаа өргөн тархсан боловч цахим контентын чанар, баримт мэдээллийн үнэн бодит байдал, түүнд хяналт тавих, баримт нотолгоонд суурилсан байх зэрэг ёс зүйн удирдамж нэн чухал хэвээр байна.

Монголчуудын нийгэм-улс төрийн чиг баримжаа дахь рационал эгоизм болон шашны хүчин зүйлсийн хамаарлаар авч үзвэл үндэсний үзэл ба гэрлэлтийн хандлага нь харьцангуй прагматик сонголтоор илэрхийлэгдсэн. Судалгаанд оролцогчдын 54.5 хувь нь өөрийгөө

“үндсэрхэг үзэлтэй” хэмээн тодорхойлсон ч тэдний үйлдэл нь прагматик эгоизм дээр тулгуурлаж байна. Үүнийг илүү нарийвчилбал: “Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага” сэдэвт олон нийтийн санаа бодлын судалгаанд оролцогчдын тоо мэдээлэлд шинжилгээ хийхэд “цус цэвэр байх үзэл”-ийг илүүтэй дурдсан нь биологийн ижилсэл гэхээсээ илүүтэйгээр нийгмийн баялаг, нөөц боломжийг “өөрийн бүлэг”-г хадгалах гэсэн рационал хамгаалалтын механизмыг бий болгож байна. Харин гэрлэлт болон глобалчлалын хувьд судалгаанд оролцогчдын 37.1 хувь нь “Сайхан амьдарч байвал заавал эх орондоо амьдрах албагүй” (УТЭЗС, Философийн хүрээлэн, 2019) хэмээн үзсэн нь М.Олсоны “хамтын үйлдлийн логик” онолоор тайлбарлагдах боломжтой хэмээн үзэж болох юм. Үүнээс үзэхэд, хувь хүн системийн ашиг сонирхлоос (эх оронч үзэл) илүүтэйгээр өөрийн амьдралын чанарыг (рационал эгоизм) дээгүүрт тавьж байгаа явдал бөлгөө. Нөгөөтээгүүр хувь хүн өөрийн амьдралын чанар, аюулгүй байдал, сэтгэл зүйн тав тухыг нэн тэргүүнд тавьж, эх оронч үзлийг хоёрдугаарт тавих хандлагатай байгааг илтгэж байна. Энэ бол глобалчлалын үед хувь хүний эгоист сонголт нь үндэсний хамаарлыг даван гарч болохыг харуулсан рационал хандлага хэмээн үзэж болох юм. Уламжлалт үнэт зүйлсийн хувьд дурдсан судалгаанд оролцогчдын 63 хувь нь “Уул усанд эзэн байдаг” гэсэн итгэл үнэмшлийг илүүтэй дэмжсэн (УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, 2019) нь үндэсний үзлийг хадгалах гэсэн хамтын ашиг сонирхлын илэрхийлэл гэж үзэийн зэрэгцээ рационал сонголтын онолоор бол зөвхөн материаллаг үр ашгийг тооцоолохоос гадна соёлын болон сэтгэл зүйн ашиг тусыг ч харгалзан үздэг болохыг харуулж буй үзэгдэл мөн (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Тоон үр дүнгээс гарсан гол дүгнэлтүүд

| Үзүүлэлт | Тоо/түвшин | Аналитик тайлбар |
|--------------------------------|------------|---|
| Өөрийгөө үндсэрхэг гэж үзсэн | 54.5% | Үндэсний ижилсэл өргөн тархсан, гэхдээ шаталсан ба прагматик шинжтэй. |
| Улс төр-үндэс угсааны хамаарал | 76.7% | Хошуучлагчийн легитимчлэлд үндэсний ижилсэл нэн чухал. |

| | | |
|-----------------------------------|-------|---|
| Улс төр-үзэл баримтлалын хамаарал | 58.0% | Норматив байр суурь ба бодлогын чиг баримжаа хүчтэй хэвээр. |
| Улс төр-шашны хамаарал | 50.0% | Шашин нь дунд түвшний боловч тогтвортой ёс суртахууны шалгуур. |
| Буддын шашинг дэмжсэн | 45.7% | Буддизм нь “өөрийн” соёлын ойр байдал, уламжлалын тэмдэглэгээ. |
| Реформист хэв маяг | 44.9% | Өөрчлөлтийн эрэлт өндөр боловч бүрэн тасархай биш. |
| Революционист хэв маяг | 26.1% | Системийн үр ашиггүй байдлын талаарх хүчтэй шүүмжлэл. |
| Консерватив хэв маяг | 24.6% | Тогтвортой байдал, уламжлал, танил ёс суртахууны хүрээг хамгаалах хандлага. |

Тэмдэглэл. Хүснэгтэд өгөгдлөөс шууд урган гарсан гол тайлбаруудыг нэгтгэв.

Дурдан буй сэдвийн хүрээнд монголын улс төрийн харилцаан дахь рационализм ба эгоизмын үзэл санааг шашны нөлөөллөөр нь авч үзэхдээ дараах гурван хүрээг хамруулан шинжилгээ хийж хураангуй дүгнэлтийг доорх байдлаар танилцуулж байна.

Улс төрийн намуудын стратеги ба цахим ардчилал: Улс төрийн намууд нь оршин тогтнох, эрх мэдлээ хадгалах, сонгуульд ялах гэсэн үндсэн зорилгодоо хүрэхийн тулд рационал шийдвэр гаргадаг. Өнөөгийн технологийн дэвшил, ялангуяа цахим орчин нь эдгээр зорилгод хүрэх шинэ рационал арга замыг намуудад олгодог чухал байр суурь эзэлдэг. Учир нь улс төрийн намууд цахим ардчиллыг хөгжүүлэх замаар гишүүнчлэлийн бодлогодоо шинэчлэл хийж, илүү өргөн хүрээний дэмжигчдийг татахыг эрмэлздэг. Энэ агуулгаараа гишүүнчлэлийн нөхцөлийг уян хатан болгох, гишүүнчлэлийн татваргүй болгох зэрэг нь гишүүн элсэлтийг нэмэгдүүлэх, санхүүгийн саадыг багасгах зорилготой рационал шийдвэрүүдийг гаргах нь элбэг байдаг (International IDEA, 2020)

Улс төрийн институтуудад итгэх итгэл ба сэтгэл ханамж: Өнөөгийн монголчуудын үндэсний үзлийн талаар тодруулсан судалгаанд хамрагдсан иргэдийн 72.1 хувь нь өөрийн дэмждэг улс төрийн намыг хойч үе нь дэмжих эсэхэд “огт үгүй” эсвэл “бодож байгаагүй” гэж хариулсан нь (УТЭЗС, Философийн хүрээлэн, 2019) намын үйл ажиллагааг үр ашигтай, хувь хүнд болон нийгэмд ашигтай гэж үзэхгүй байгаагийн илэрхийлэл юм. Энэхүү хандлага нь

иргэд намуудаас ашиг тус хүртэхгүй байгаа тохиолдолд үнэнч байдал багасч, рационал байдлаар үнэлгээ өгч байгаа явдал хэмээн тайлбарлаж болох юм. “Сант Марал сан”-ийн болон “Улс төрийн барометр”-ийн давтамжит судалгаагаар (2021) УИХ, хуулийн байгууллагууд, улс төрийн намуудад итгэх иргэдийн үзүүлэлт жил ирэх тусам буурч, хамгийн бага итгэл хүлээлгэдэг байгууллагууд болон хувирсныг судалгааны үр дүнгүүд харуулсан нь бий. Иргэдийн улс төрийн институтуудад итгэх итгэл буурч байгаа нь тэдгээр институтууд иргэдийн хувийн болон хамтын ашиг сонирхлыг хангаж чадахгүй, үр ашиггүй ажиллаж байгааг илтгэсэн рационал үнэлгээ болохын тод илэрхийлэл юм.

Авлига ба рационал эгоизм: Авлига нь монголын нийгмийн эмзэг асуудлуудын нэг бөгөөд рационал эгоизмын тод жишээ юм. “Монголын улс төрийн хүрэн дэх авлигын нөхцөл байдлын шинжилгээ” сэдэвт бодлогын судалгаагаар (Хатанболд О, 2021) авлигад холбогдож буй хувь хүмүүс өөрсдийн хувийн ашиг сонирхол, шунал тачаалыг (эгоист хандлага) дээдлэн, үр ашгийг рационалаар тооцоолж, хууль ёсыг зөрчиж байгааг онцолсон. Энэ нь нийгмийн тогтолцоонд итгэх итгэлцэл сул байгаа, хариуцлагын механизм хангалтгүй байгаа нөхцөлд илүү түгээмэл ажиглагддаг (Төгөлдөр Я, Мягмарсүрэн Д, ба бусад., 2021, хуудсд. 101-102). Монгол Ардын Нам (МАН) болон Ардчилсан Нам (АН) нь хамгийн их авлигад автсан гэж шинжээчдийн 73 хувь үзсэн нь улс төрийн намууд өөрсдийн эрх мэдлийг

хувийн ашиг сонирхолд ашиглаж байна гэсэн нийгмийн үнэлгээг илтгэнэ (УТЭЗС, Философийн хүрээлэн, 2019).

Геополитик, шашин, үндэсний ашиг сонирхлын огтлолцоолоос харахад: Монгол Улсын геополитикийн байрлал нь рационал эгоизмын улсын түвшний тайлбарыг шаарддаг. Хоёр том гүрний дунд орших жижиг улс тусгаар тогтнолоо хадгалах, эдийн засгийн хараат байдлыг бууруулах, олон талт аюулгүй байдлын сүлжээ бий болгох шаардлагатай тулгардаг. Энэ нөхцөлд гуравдагч хөршийн бодлого нь романтик дипломат уриа бус, харин эмзэг орчныг тэнцвэржүүлэх рационал улсын эгоизмын бодлого юм. Монгол Улс бусад том, дунд хүчнүүдийн ашиг сонирхлыг өөрийн тогтвортой байдалтай холбох замаар аюулгүй байдлаа өргөтгөдөг.

Үндэсний үзэл энэ түвшинд зөвхөн соёлын бахархал биш, харин гадаад орчны дарамтыг дотоод нэгдэл болгон хөрвүүлэх сэтгэлзүй-улс төрийн механизм болж байна. Ийм учраас иргэдийн дунд үндэсний ижилслийн шалгуур өндөр байх нь геополитикийн эрсдэлийг соёлын хэлээр дотоодчлон ойлгож буйн илрэл гэж тайлбарлаж болно. Жижиг улс өөрийн түүх, соёл, шашны өвийг стратегийн нөөц болгон ашиглах нь рационал сонголтын нэг хэсэг юм.

Шашны хүчин зүйл геополитикийн кейст хоёрдмол үүрэгтэй. Нэг талаас уламжлалт буддизм нь түүхэн ой санамж, соёлын залгамж чанар, дотоод ёс суртахууны хяналтыг бэхжүүлж, нийгмийн эв нэгдэлд эерэг нөлөө үзүүлж болно. Нөгөө талаас шашны ил тод бус санхүүжилт, гаднын сүлжээ, хэт туйлширсан

нөлөөлөл нь эмзэг орчинд улс төрийн болон үнэт зүйн нэвтрэлтийн сувгийг нээж болзошгүй. Шашныг дэмжих эсэх асуудлыг зөвхөн “уламжлал - шинэчлэл” гэсэн хоёр туйлт сөргөлдөөнөөр бус, “үндэсний соёлын тогтвортой байдал - гаднын нөлөөллийн эрсдэл - институцийн ил тод байдал” гэсэн гурвалсан хүрээнд авч үзэх нь оновчтой.

Геополитикийн эрсдэлт нөхцөл байдалтай холбож үзвэл шашны болон үндэсний шалгуурын дунд түвшний нягтрал нь аюулгүй байдлыг зөвхөн цэрэг-дипломатын хэмжээсээр бус, соёлын тогтвортой байдал, үнэт зүйн бат бөх чанараар ойлгож байгааг илтгэнэ. Жижиг улсын хувьд дотоод ёс суртахуун, итгэлцэл, үндэсний хамтын ижилсэл нь гадаад дарамтыг шингээх чадвартай зөөлөн нөөц болдог. Иймээс улс төр-шашны хамаарал нь теократ хүсэл биш, харин геополитикийн эмзэг орчинд найдвартай байдлын нэмэлт баталгаа эрж буй иргэний сэтгэлгээний илэрхийлэл гэж тайлбарлаж болно.

Өнөөгийн Монголын нийгэм, улс төрийн харилцаанд рационализм ба эгоизмын хандлагууд тод илэрч байгаа нь уламжлалт үнэт зүйлс, соёлын онцлогийг хадгалах, хамгаалах үүднээс хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн хувийн болон хамтын ашиг сонирхлыг дээдлэх, оршин тогтнох, хөгжих гэсэн рационал тооцооллоор тайлбарлагдаж байна. Түүнчлэн гэр бүлийн харилцаа, хамтын ажиллагаа, улс төрийн үнэлгээ зэрэгт хувь хүний үр ашиг, хувийн сонголтууд нэн тэргүүнд тавигдах болсон нь даяаршил болон ардчиллын үр дүн гэж үзэж болох юм.

4. Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс үзвэл Монголын нийгэм-улс төрийн харилцаанд рационал эгоизм нь гурван үндсэн сувгаар илэрч байна. *Нэгдүгээрт*, үндэсний ижилсэл нь “өргөтгөсөн би”-гийн логикоор хувь хүний аюулгүй байдал, нэр хүнд, боломжийн бүтцийг хамгаалах хамтын рационал эгоизмын хэлбэр болж байна. *Хоёрдугаарт*, шашин, ялангуяа буддизм нь улс төрийн шууд ноёрхлын шаардлагаас илүүтэйгээр итгэлцэл, өөрийгөө хязгаарлах ёс

суртахуун, хамтын амьдралын хариуцлагыг дэмждэг ёс суртахууны соёлын капиталын үүрэг гүйцэтгэж байна. *Гуравдугаарт*, геополитикийн эмзэг байршил нь үндэсний ашиг сонирхлыг урт хугацааны тооцоолол, тэнцвэржүүлэх бодлого, дотоод нэгдэлтэй холбож тайлбарлах шаардлагыг төрүүлж байна. Иймээс улс төр-шашны дунд түвшний хамаарал нь Монголын нийгэмд теократ улс төрийн эрэлт хүчтэй байгааг бус, харин институцийн итгэл сул,

геополитикийн орчин эмзэг үед ёс суртахууны найдвартай байдал, соёлын тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдлыг хамтад нь үнэлэх хандлага хүчтэй байгааг илтгэнэ. Энэ нь өгүүлэлд дэвшүүлсэн “ёс суртахууны соёлын капитал” гэсэн ойлголтыг эмпирик тайлбарын хувьд үр өгөөжтэй болгож байна.

Дурдан буй сэдвийн хүрээнд шашны хүчин зүйл нь монголын улс төрийн хошуучлалын сонголт болон иргэдийн улс төрийн үйл явцад хандах хандлагад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Тухайлбал, үндэсний угсаа гаралтай хүчтэй корреляци (76.7%)-ийн хамааралтай үндэсний үзэл ба хамтын эгоизм нь улс төрийн сонголтод чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Тус өгүүлэлд ашигласан судалгааны үр дүнд шинжилгээ хийхэд, судалгаанд оролцогчдын хувьд буддизмыг “өөрийн” шашин хэмээн дэмжих хандлага нь соёлын өв, үндэсний онцлогийг хадгалахыг хичээсэн рационал болон эгоист сонголттой уялдахаас гадна гадны шашны нөлөөг эсэргүүцэх нь хамтын эгоизмын илэрхийлэл болж буйг илэрхийлж байна.

Улс төрийн намуудын гишүүнчлэлийн бодлого болон цахим ардчиллын хөгжил нь рационализм болон эгоизмын онолын хандлагуудаар тайлбарлагдах олон талтай үзэгдэл юм. Нэг талаас, намууд цахим ардчиллыг эрх мэдэл, олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, үр ашигтай үйл ажиллагаа явуулах рационал хэрэгсэл болгон ашиглаж байна. Нөгөө талаас, намуудын доторх клиентелизм, патронаж, авлига хээл хахууль болон сонгуулийн богино хугацааны ашиг сонирхлыг дээдлэх нь намуудын болон тэдний удирдагчдын эгоист хандлагыг тодоор харуулж байна. Харин иргэдийн улс төрийн намын гишүүнчлэл нь хувийн ашиг сонирхлыг хөөсөн эгоист сонголтуудтай холбоотой байх магадлалтай бол, намуудад итгэл буурч байгаа нь иргэдийн хувьд өөрсдийн эрх ашиг, нийгмийн хэрэгцээ хангагдахгүй байгааг илэрхийлсэн рационал үнэлгээ юм. Иймд монголын улс төрийн намууд цахим ардчиллын давуу талыг ашиглан олон нийттэй харилцах, гишүүнчлэлээ өргөжүүлэхдээ зөвхөн эрх мэдлээ хадгалах гэсэн эгоист зорилгоос ангид байж, илүү нээлттэй, ил тод, үр дүнтэй байдлаар

нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн рационал бодлогыг баримтлах шаардлагатай тулгарч байна. Намуудын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, гишүүнчлэлийн бодлогод суурьтай өөрчлөлт хийх нь цахим ардчиллыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, иргэдийн итгэлийг сэргээх, улмаар улс орны тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой.

Бодлогын түвшинд дараах гурван саналыг дэвшүүлж болохоор байна. *Нэгдүгээрт*, үндэсний үзлийг хаалттай туйлшрал бус, нийтийн ашиг сонирхол, иргэний хариуцлага, институцийн шударга байдлыг дэмжих иргэний хүрээнд хөгжүүлэх шаардлагатай. *Хоёрдугаарт*, шашны байгууллагын ил тод байдал, ёс зүйн стандарт, олон нийтийн сайн сайхны чиглэл дэх хамтын ажиллагааг дэмжихийн зэрэгцээ төр-шашны секуляр заагийг тодорхой хадгалах нь зүйтэй. *Гуравдугаарт*, геополитикийн эмзэг орчинд иргэдийн итгэлцэл, институцийн чанар, авлигын эсрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь урт хугацааны рационал эгоизмын институцийн суурь болно.

Энэ бүхнээс нэгтгэн дүгнэхэд Монголын нийгмийн шилжилт нь примитив, богино хугацааны аминч байдлаас урт хугацааны, хариуцлагатай, хамтын тогтвортой байдлыг тооцсон рационал эгоизм руу хөдөлж буй үйл явц юм. Үндэсний үзэл ба шашны үнэт зүйлс нь энэ шилжилтийг зөв удирдвал нийгмийн эв нэгдэл, итгэлцэл, аюулгүй байдлын нөөц болж чадна; буруу удирдвал ялгарал, популизм, институцийн сулралыг гүнзгийрүүлэх эрсдэлтэй. Тэдгээрийг шүүмжлэлтэй, хэмжилттэй, бодлогын түвшинд хариуцлагатай авч үзэх нь чухал юм.

Энэхүү өгүүлэлд өнөөгийн монголын нийгмийн харилцаанд, тухайлбал улс төрийн сонголтод шашны хүчин зүйл хэрхэн нөлөөлж, рационал болон эгоист хандлагуудтай хэрхэн уялдаж байгааг тодорхой харуулахыг хичээсэн болно. Ингэхдээ үндэсний үзэл, соёлын онцлогийг хамгаалахтай холбоотойгоор буддизм болон бөө мөргөлийг дэмжих нь хамтын эгоизмын илэрхийлэл болж байгаа бол, шашнаас үл хамааран улс төрийн үйл явцад үр

ашиг харагдахгүй болоод идэвхгүй байх нь хувийн рационал сонголт юм.

Монголын нийгэм хувьсан өөрчлөгдөж буй ч, соёлын суурь үнэт зүйлс нь хэвээр хадгалагдан, орчин үеийн хандлагуудтай хосолж, өвөрмөц холимог бүтцийг үүсгэж буйг харуулж байна. Түүнчлэн иргэдийн улс төрийн нам, институтуудад итгэх итгэл буурч байгаа нь эдгээр байгууллагууд иргэдийн хувийн болон хамтын ашиг сонирхлыг хангаж чадахгүй, үр ашиггүй ажиллаж байна гэсэн рационал үнэлгээтэй холбоотой. Энэ нь улс төрийн намууд өөрсдийн эрх ашиг, сонгуульд ялах гэсэн богино хугацааны эгоист зорилгуудад хэт төвлөрч байгаагийн үр дүн гэж болно. Цаашид Монголчуудын нийгмийн харилцаа, улс төрийн сонголтод уламжлал, рационал сонголт, эгоист хандлагын харилцан үйлчлэл, мөн шашны хүчин зүйлийн нөлөөг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна. Ингэснээр Монголын нийгмийн болон улс төрийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үр өгөөжтэй шийдвэрүүдийг гаргахад ач тустай байх болно.

Рационал эгоизмын онолын үзэл баримтлалыг нийгэм, улс төрийн харилцааны бодит хүчин зүйлс болох үндэсний үзэл болон шашны нөлөөлөлтэй уялдуулан шинжлэхийг чухалчилсан. Энэ хүрээнд дараах үндсэн дүгнэлт, саналыг дэвшүүлж байна.

Нэгд, рационал эгоизм нь зөвхөн хувь хүний “*би*” төвт үзэл бус, харин нийгмийн тогтвортой байдлыг хангах “*ухаалаг прагматизм*” мөн болох нь ажиглагдаж байна. Үүнийг сонгодог философичдын (Т.Гоббс, А.Смит) тодорхойлсончлон хүн төрөлхтөн аюулгүй байдал, ашиг тусаа хангахын тулд нийгмийн гэрээ байгуулдаг нь угтаа хамгийн өндөр түвшний рационал эгоист үйлдэл юм. Өөрөөр хэлбэл, хувь хүн өөрийнхөө эрх ашгийг нийтийн сайн сайхнаас тусад нь салгаж авч үзэх боломжгүй бөгөөд нийгмийн дэг журам, хууль ёсыг сахих нь эцсийн дүндээ хувийн өмч, амь нас, эрх чөлөөгөө хамгаалж буй хэрэг бөлгөө.

Хоёрт, үндэсний үзэл нь рационал эгоизмыг хамтын түвшинд хэрэгжүүлэгч “*сэтгэл зүйн болон улс төрийн дэд бүтэц*” болсоор байна. Үүнийг Р.Белкийн тодорхойлсон “*өргөтгөсөн би*” (*extended self*) хэмээх

ойлголтоор дамжуулан иргэд үндэстнийхээ амжилт, тусгаар тогтнолыг өөрийн амжилт мэтээр хүлээн авч байгаа нь үндэсний үзлийг сохор туйлшрал гэхээс илүүтэйгээр, хувь хүний оршин тогтнох баталгааг хангах хамтын стратеги гэж харах боломжийг олгож байна. Харин Монгол Улсын хувьд үндэсний ижилсэл нь геополитикийн болон эдийн засгийн эрсдэлийг даван туулах рационал хэрэгсэл болж байна.

Гуравд, шашны хүчин зүйл нь нийгмийн харилцааны “*итгэлцлийн зардлыг бууруулагч*” механизм болох нь Фрэнсис Фукуямагийн “*нийгмийн капитал*”-ын онолоор илэрхийлэгдэхийн сацуу итгэлцэл өндөртэй нийгэмд эдийн засаг, улс төрийн харилцааны зардал бага байдаг аж. Угтаа шашин болон уламжлалт ёс зүйн хэм хэмжээ (*үйлийн үр, нүгэл буян*) нь хүмүүсийг “*дотоод хяналт бүхий хэм хэмжээ*”-тэй болгосноор примитив буюу богино хугацааны аминч үйлдлийг хязгаарлаж, нийгэмд хариуцлагатай, илүү ухаалаг/“*рационал*” эгоист байх соёлыг төлөвшүүлж байна.

Дөрөвт, Монголын нийгэмд тулгамдаж буй авлига, хариуцлагагүй байдал зэрэг нь рационал эгоизм дутагдсаны илрэл юм. Хэрэв иргэн, албан тушаалтнууд зөвхөн өнөөдрийн ашгийг харж байгаа бол, энэ нь рационал бус үйлдэл бөгөөд урт хугацаандаа өөрийнхөө амьдрах орчныг нурааж буй хэрэг мөн. Иймээс үндэсний үзэл ба шашны үнэт зүйлсийг рационал сонголттой хослуулах замаар нийгмийн гишүүдийг илүү алсын хараатай, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх нь улс орны хөгжлийн гол гарц болно.

Энэ бүхнээс үзэхэд, рационал эгоизмын онолын хувьсал өөрчлөлтийг түүхэн үе шатууд болон орчин үеийн чиг хандлагатай харьцуулан дүгнэвэл түүхэн үндэслэлээс орчин үеийн парадигм рүү чиглэсэн үйл явц гэж үзэж болохоор байна. Учир нь рационал эгоизмын үзэл санааг нийгэм, улс төрийн контекстоор авч үзвэл онолын хувьсал нь “*оршин тогтнохын төлөөх тэмцэл*”-ээс “*үр ашигтай хамтын ажиллагааны стратеги*” руу шилжиж ирсэн. Энэхүү өгүүллээрээ дээр дурдсан судалгааны үр дүнгээр монголын нийгмийн шилжилт нь

примитив, богино хугацааны аминч байдлаас урт хугацааны, хариуцлагатай, хамтын тогтвортой байдлыг тооцсон рационал эгоизм руу хөдөлж буй үйл явц юм. Үндэсний үзэл ба шашны үнэт зүйлс нь энэ шилжилтийг зөв удирдвал нийгмийн эв нэгдэл, итгэлцэл, аюулгүй байдлын нөөц болж чадна; буруу удирдвал ялгарал, популизм, институцийн сулралыг гүнзгийрүүлэх эрсдэлтэй. Ийм учраас тэдгээрийг шүүмжлэлтэй, хэмжилттэй, бодлогын түвшинд хариуцлагатай авч үзэх нь чухал юм.

Ном зүй / References:

- Jorgensen M.B., Phillips L.J. (2002). *Discourse Analysis as Theory and Method*. SAGE Publications, 67.
- Johnson, David W. Johnson, Roger T. (2000 оны May). *Civil Political Discourse in a Democracy: The Contribution of Psychology*. www.co-operation.org/pages/contro-pol.html.
- Оюунгэрэл Д. (2018). Ёс суртахууны боловсрол нь боловсролын философийн чухал асуудал болох нь. *Философи, эрхийн судлал*(XXXIII), 57-58.
- Даш-Ёндон Б. (2017). *Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус)*. ((Ч. Г., Хян.) Улаанбаатар хот, Монгол Улс: Философийн хүрээлэн, ШУА, «Соёмбо принтинг» ХХК.
- Хүрэлбаатар Л. (1996). *Огторгуйн цагаан гарди*. ((Ш. Б., Хян.) Улаанбаатар хот, Монгол Улс: Хэл зохиолын хүрээлэн, ШУА, «Өнгөт хэвлэл» ХХК.
- Явуухулан Б. (1985). *Түүвэр зохиол*. Улаанбаатар хот, Монгол Улс: Улсын хэвлэлийн газар.
- Баасансүрэн Д, Хишигдаваа А, ба бусад. (2020). *Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал ба орчин үе. Хамтын бүтээл*. (Б. Д. Хатанболд О, Хян.) Улаанбаатар хот, Монгол Улс: УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, "Соёмбо принтинг" ХХК.
- УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. (2019). *Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага*. Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбар. Улаанбаатар хот: Философийн хүрээлэн, ШУА.
- УТЭЗС, Философийн хүрээлэн. (2019). *Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага. ОНСБ-ын судалгааны тайлан*. Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбар. Улаанбаатар хот: Философийн хүрээлэн, ШУА, "Тод бичиг" ХХК.
- International IDEA. (2020).
- Хатанболд О. (2021). Монголын улс төрийн хүрээн дэх авлигын нөхцөл байдлын шинжилгээ. Бодлогын судалгаа. М.-и. У. Конрад Аденаурын сан, & Г. С. Төртогтох Ж (Хян.)-Д, *Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан асуудал, цаашдын хандлага. Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж* (хууд. 117). Улаанбаатар хот: Монгол дахь Конрад Аденаурын сангийн төлөөлөгчийн газар.
- Төгөлдөр Я, Мягмарсүрэн Д, ба бусад. (2021). *Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал*. Улаанбаатар хот, Монгол Улс: ННФ, ШУТИС.
- Хишигдаваа А, Цанжид А, Жаргал Ц, ба бусад. (2024). *Монгол дахь улс төрийн хошуучлал: өнөөгийн байдал, төлөв хандлага. Хамтын бүтээл*. (Т.-О. С. (ред) Батхишиг Б, Хян.) Улаанбаатар хот, Монгол Улс: УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА.
- Marianne Jorgensen, Louise Philips. (2002). *Discourse Analysis as Theory and Method*. London – Thousand Oaks – New Delhi: SAGE Publication.
- УТЭЗС, Философийн хүрээлэн. (2024). *Монгол дахь улс төрийн хошуучлал: өнөөгийн байдал, төлөв хандлага*. (Т.-О. С. Батхишиг б, Хян.) Улаанбаатар хот, Монгол Улс: УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, "Соёмбо принтинг" ХХК.
- N.G.Chernyshevsky. (1863, (2nd edited translation 1989)). *What Is to Be Done? [Что делать?]*. Cornell University Press.
- Thomas Hobbes. (1651). *Leviathan*. Penguin Classics (1982).

- Rand A. (1964). *The Virtue of Selfishness: A New Concept of Egoism*. Signet.
- Axelrod R. (1984). *The Evolution of Cooperation*. . Basic Books Publishers.
- Adam Smith. (November 19, 2015). *The Wealth of Nations*. (L. v. Mises, Хян.) An Electronic Classics Series Publication.
- Russell W.Belk. (1988). Possessions and the Extended Self. *15*(2), 139-168.
- Van den Berghe. (1981). *The Ethnic Phenomenon*. Elsevier.
- Yael Tamir. (1993). *Liberal Nationalism*. Princeton University Press.
- Allexis de Tocquille. (1835). *Democracy in America*. Penguin Classics, 2003.
- Fukuyama F. (1995). *Trust: The Social Virtues and the Creation of Prosperity*. Free Press.
- Coase R.H. (1937). The Nature of the Firm. *Economica*, 4(16), 386–405.
- Fukuyama F. (2011). *The Origins of Political Order*. Farrar, Straus and Giroux Publishers.
- North D.C. (1990). *Institutions, Institutional Change and Economic Performance*. . Cambridge University Press .
- Хатанболд О, УТЭЗС. (2025 оны 9, 10 дугаар сар). Фокус бүлгийн ярилцлага. Дорнод, Дорноговь, Орхон, Өвөрхангай аймаг: Философийн хүрээлэн, ШУА.
- УТЭЗС. (2025). "Буддын шашны нийгэм, улс төрийн үүрэг". ШУА, Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбар. Улаанбаатар: Философийн хүрээлэн, ШУА.
- Үндсэн хууль. (1992 оны 1 13). Гаргасан 2025, legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/367-аас>
- International IDEA. (2020). *New Forms of Political Members: Political Party Innovation Primer*. Stockholm: International IDEA.
- Tocqueville, A. D. (1840). *Democracy in America* .
- Adam Smith. ((1 edition) 1759; (paperback) 2009;). *The Invisible Hand*. Penguin Books Publishers (Great Ideas).
- Berghe, P. L. (2001). The homeopathy of Kin selection: An evaluation of van den Berghe`s Sociobiological approach to ethnic nepotism. *Politics and the Life Sciencess*, 20(2), 203-215.
- Belk Russell W. (1988). "Possessions and the Extended Self". *Journal of Consumer Research*, 15(2), 139-168.
- van den Berghe, P. L. (1987). *The Ethnic Phenomenon*. New York: Praeger.
- Yael Tamir. (1993). *Liberal Nationalism*. Princeton, New Jersey, USA: Princeton University Press.
- North, D. C. (1990). *Institutions, Institutional Change and Economic Performance*. Cambridge, UK: Cambridge University Press.

Geopolitics, national interest, and religious values: An analysis of Mongolia's socio-political relations from the perspective of rational egoism

Khatanbold Oidov

Ph.D

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences,

Ulaanbaatar, Mongolia

khatanboldo@gmail.com

Abstract: *This article examines how nationalism, religious values, and geopolitical calculation intersect in Mongolia's socio-political relations through the lens of rational egoism. The paper combines discourse analysis, comparative theoretical interpretation, and descriptive re-analysis of secondary survey and interview data produced between 2017 and 2026. It operationalizes rational egoism through proxy indicators such as nationalism, leadership criteria, religious affiliation, institutional trust, and political participation patterns. The findings suggest that national identity functions as a collective form of rational egoism through the logic of the "extended self"; religion, especially Buddhism, works less as a demand for theocratic politics than as a source of moral-cultural capital reducing distrust and social transaction costs; and Mongolia's third-neighbour policy and sovereignty concerns reveal rational egoism at the level of state strategy. Reported correlation patterns indicate a medium-level relationship between political-religious and geopolitical risk perceptions. The article concludes that Mongolia is moving from short-term primitive egoism toward long-term, responsibility-oriented rational egoism.*

Keywords: *rational egoism, nationalism, religion, geopolitics, Mongolia, political leadership, moral-cultural capital, trust*

| | |
|---------------------------------------|-------------------|
| <i>The day of submission:</i> | <i>2026.02.11</i> |
| <i>Completion of review:</i> | <i>2026.04.30</i> |
| <i>Final decision for acceptance:</i> | <i>2026.05.27</i> |